

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

“Ломбарданд” буй Монгол улс


Хямралыг хамтдаа
давах ухаан

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 10 сар. №20 (030)

www.mongolianeconomy.mn

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ШИНЖИХҮЙ





DISTRIBUTOR MONGOLIA 2012

**ХЭРЭВ
БҮРТГҮҮЛЖ АМЖААГҮЙ БОЛ
АМЖИЖ БҮРТГҮҮЛЭЭРЭЙ !**

**МОНГОЛ ДАХЬ АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЬУТЕР,
ХУДАЛДААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ,
ИМПОРТЛОГЧ, ДИЛЕР КОМПАНИУДЫГ УРЬЖ БАЙНА**

- Монголын зах зээлд нэрээ батлах
- Оригинал бараа бүтээгдэхүүнээ хуурамч бараанаас ялгах таниулах
 - Маркетинг, борлуулалт
- Шинэ барааг зах зээлд нэвтрүүлэх
- Бизнес уулзалтын боломжууд нэгдэнэ

*МОНГОЛ ДАХЬ ТЭРТҮЧЛЭХ ДИСТРИБЬУТЕР КОМПАНИУД
ОРЛОЦОЖ, ДЭЛХИЙН БҮХ БРЭНД НЭТ ДОР ЦУТЛАРНА*

БҮРТГЭЛ:

“Мишээл Групп” ХХК байранд бүртгэнэ.

ҮЗЭСГЭЛЭН:

2012.11.9-11-нд МИШЭЭЛ ЭКСПО ТАНХИМ-д

ҮЗЭСГЭЛЭНД БҮРТГҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГУУДДАА БАЯРЛАЛАА



88077064-88077063-95950811



PartnerDirect



DELL PowerEdge R Series



PowerEdge R420

Нягт бас хүчирхэг

Дэвшилтэт Intel® Xeon® процессортой Dell® PowerEdge™ R420 сервер нь хямд өртөгтэй, эрчим хүчинд хэмнэлттэй байхын зэрэгцээ хамгийн бага зай талбайг эзлэх U1 хэмээтэй тул таны мэдээллийн төвд хамгийн тохиромжтой, өөрчлөн сайжруулах өргөн боломжтой сервер юм.

- PCIe Gen3; PCIe Gen2; GbE; CacheCade; NIC зэрэг мэдээллийг өндөр хурдаар дамжуулах холболтын өргөн боломжуудтай
- Санах ойг 192GB хүртэл нэмэгдүүлэх, 8 хүртэл 2.5"-ийн хатуу диск холбох
- Ердөө 1U хэмжээтэй тул Rack-ний зай талбай ашиглалтыг нэмэгдүүлнэ
- Дуу чимээ багатай



PowerEdge R520

Өргөтгөн сайжруулах өргөн боломжтой хүчирхэг төхөөрөмж

Тохиргоо, өөрчлөлт хийх өргөн боломжтой Dell® PowerEdge™ R520 сервер нь их хэмжээний мэдээллүүдтэй ажилладаг програмуудыг суурилуулан ашиглахад хамгийн тохиромжтой төхөөрөмж бөгөөд ирээдүйд гарах аливаа шинэ хэрэгцээ шаардлагад шинэчлэгдэн өөрчлөгдөж нийцэх чадвартайгаараа онцлог болсон.

- 2.5"; 3.5"-ийн 8 хүртэл тооны SAS, SATA, SSD төхөөрөмжүүдийг ашиглах
- Багтаамжийг 24TB хүртэл нэмэгдүүлэх
- 4 ширхэг өндөр хурдаар мэдээлэл дамжуулах PCIe Gen3 холболт /Өмнөх PCIe Gen 2 холболтоос хоёр дахин хурдан мэдээлэл дамжуулах боломжтой/
- Засвар үйлчилгээний хугацааг хурдасгах Dell®-ийн PowerEdge™ RAS функцтэй




PowerEdge R720

Шинэ үеийн дэвшилтэт гүйцэтгэл

Виртуалчлалын бүхий л хэрэгцээ шаардлагыг хангах Dell® PowerEdge™ R720 төхөөрөмж нь өндөр хурдтай тооцоо, гүйцэтгэл хийх шаардлагатай програм хангамжуудад хамгийн тохиромжтой сервер юм. Процессор бүртээ 8 цөмийг агуулах Intel® Xeon® E5 – 2600 олон цөмт-процессортой энэхүү төхөөрөмж сервер бүрт оногдох виртуал серверийн тоо хэмжээг нэмэгдүүлж, асар өндөр хурдтай гүйцэтгэлийг хүргэнэ.

- 24 хүртэл тооны DIMM санах ойг суурилуулж, санах ойг 384GB хүртэл нэмэгдүүлэх
- PCIe, GbE, 10GbE зэрэг онцгой хурд бүхий сүлжээний дэвшилтэт холболтуудаас сонгох
- Серверийн удирдлагыг физик байдлаар, виртуал орчинд, сүлжээгээр, бүр алсын зайнаас удирдах боломжтой
- Мэдээлэл алдагдах аюулаас сэргийлэх хос RAID технологитой



М-Си-Эс Электроникс ХХК

Сэнтрал Тауэр, 14 давхар СБД-8,
Сүхбаатарын талбай
Улаанбаатар 14200, Монгол улс
Утас: 312424, Факс: 312699
Вэб: www.electronics.mcs.mn

312424

ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН СУРГАЛТ ЗӨВЛӨГӨӨГ НЭВТРҮҮЛСЭНЭЭР

- ☘ QMS ISO 9001:2008-Чанарын удирдлагын тогтолцоо
- ☘ EMS ISO 14001:2004-Байгаль орчны тогтолцоо
- ☘ FSMS ISO 22000:2005-Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо
- ☘ OHSAS 18001:2007-ХАБЭА -ын тогтолцоо
- ☘ НАССР-Эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо



M.R C&C



СУРГААМ



M.R C&C Co.,Ltd

- ☑ Тогтолцооны сургалт
- ☑ Чиглүүлэх сургалт
- ☑ Дотоод аудитын сургалт
- ☑ Дотоод аудит хийх зөвлөгөө

Add: №505, Kyokushu tower building
Bayangol district, Ulaanbaatar
Mongolia
Tel: 9910 4027 9910 3631
E-mail: mrcc3090@yahoo.com



M.R C&C



PartnerDirect



DELL PowerVault MD3600f



PowerVault MD3600f Fibre Channel Storage Array

Dell PowerVault MD3600F storage серверийн тусламжтай та байгууллагынхаа мэдээллийн баазын багтаамжийг илүү хямд өртгөөр нэмэгдүүлэх боломжтой.

Дэвшилтэт гүйцэтгэл, өндөр багтаамжийн нэгдэл

PowerVault MD3600 ангиллын төхөөрөмжүүдийн тусламжтай хянахад болон ашиглахад хүндрэлтэй байдаг асар их хэмжээний мэдээллүүдийг хялбархан удирдах боломжтой болно. Энэхүү шилэн кабелийн холболт бүхий төхөөрөмж нь танай байгууллагын мэдээллийн баазтай шууд холбогдох бөгөөд Microsoft® Hyper-V™, Citrix® XenServer® болон VMWare® ESX зэрэг технологиудтай нийцэж ажиллана.

- 3.5"-ийн болон 2.5"-ийн хатуу дискийг хольж байрлуулах боломжтой
- 12,24 хатуу дискний багтаамжтай 2U хэмжээтэй загвар болон 60 хатуу диск багтаах 4U хэмжээнээс сонгох боломжтой

Мэдээллийн хяналтанд зарцуулах хугацааг багасгана

MD Storage Manager болон VMWare® vCenter™ 5.0 технологиудын тусламжтай физик болон виртуал нөөцүүдэд тавигдах хяналтанд зарцуулах хугацааг багасгана. Дээрх технологиуд нь серверт учирсан аливаа биет гэмтэл, алдааг автоматаар оношилж, засварлах процессийг эхлүүлэн, анализ гаргах; виртуал орчин дахь мэдээллийг илүү үр дүнтэй зохион байгуулж нөөцийг нэмэгдүүлэх зэрэг боломжийг олгоно.



Storage сервер гэж юу вэ?

Storage server нь их хэмжээний мэдээлэлтэй ажиллахаар тусгайлан зохицуулагдсан, хялбарчилсан үйлдлийн системтэй, богино хугацаанд анализ, боловсруулалт хийх програм хангамжтай, маш олон тооны хатуу дискийг агуулах боломжтой байдгаараа бусад энгийн серверүүдээс онцлог.

М-Си-Эс Электроникс ХХК

Сэнтрал Тауэр, 14 давхар СБД-8,
Сүхбаатарын талбай
Улаанбаатар 14200, Монгол улс
Утас: 312424, Факс: 312699
Вэб: www.electronics.mcs.mn

312424

Ногоон хөгжлийн пөлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

□□□□□□□□□□ □□□□□□ □□□□□□ □□□□□□

Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Б.Үүрийнтуяа

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР:

Ш.Оюундарь

□□□□□□□□□□:

□.□□□□□□□□□□

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /8880-0825/

□.□□□□□□□□ /9902-2279/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш

“ECONOMY” ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ:

Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН

Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

ΑΙΘΕΡΟΪΑΘ ΟΥΑ ---Α:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" □□□□□□□□

“Οὐαίίίίίίίίίί ίδείθ” ΟΪΕ-а οὐαεῦα

www.ubprint.mn

“Mongolian Economy” сэтгүүлийн IV улирлын нэмэлт захиалга явагдаж байна

ЗАХИАЛГЫГ:

“Монгол шуудан”

“Түгээмэл шуудан”

“Sky” шуудан

“UB Post” шуудангийн салбарууд болон
сэтгүүлийн редакцид авч байна.

УТАС: 7011-5476
8880-0825
9905-1914



Давааны цаадах даваа

...Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, гадаадын хөрөнгө оруулагчдын хайрыг татах чухал алхам бол тус зэрэглэлд багтах. Тиймээс ирэх жилийн хөрөнгийн зах зээлийн өнгө төрхөөс их зүйл хамаарах нь...11

Даатгал тойрсон асуудал

.Манайх шиг албан журмын даатгалын ойлголт буруу, сайн дурын даатгалын талаарх мэдлэг тааруу, салбарын хөгжил сул зах зээлд даатгуул хэмээн дээрээс “зарлигдах” нь тийм ч зөв арга биш ...24



“Эмэгтэйчүүд тэнгэрийн талыг дааж явдаг”



2000 гаруй хүн амиа алдсан цуст мөргөлдөөнийг таслан зогсоож, улсаа эмх цэгцэнд оруулах үүднээс байгуулагдсан түр Засгийн газрыг Роза Отунбаева намынхаа бүрэн дэмжлэгтэйгээр тэргүүлж, улмаар ерөнхийлөгчийн албыг 2011 оны эцэс хүртэл хашиж байсан билээ. Улсынхаа хувь заяаг тэгшитгэсэн эмэгтэй ерөнхийлөгч гэдгээрээ нэрд гарсан Роза Отунбаеватай манай сэтгүүлч ярилцсаныг ..34

Тавантолгойн нүүдэл

...Тавантолгойн ордод анхаарал хандуулах ажлын хэсэг бүрдлээ. Уул уурхайн сайд Д.Ганхуягаар ахлуулсан ажлын хэсэг уг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрт ихээхэн анхаарах бодлогыг баримталж буй аж. Учир нь дэлхийн зах зээлд төдийгүй өмнөд хөршид нүүрсний үнэ шалдаа буусан тул “саваа бэлдэх”-ээр шийджээ...37



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

- 10 Тарьсан мод хэрхэн нахиалах бол
- 11 Давааны цаадах даваа
- 14 “Ломбарданд” буй Монгол Улс
- 19 Хөгжлийн засаглал
- 19 Сонгуулийн эдийн засаг
- 22 Г.ЦЭВЭГЖАВ: Манайх “Тогтвортой”-гоос ч илүү үнэлгээ авах боломжтой
- 24 Даатгал тойрсон асуудал
- 28 Хөрөнгийн зах зээлийг “хөгжиж буй” зэрэглэлд багтаана

ЭДИЙН ЗАСАГ


- 30 Дэлхийн эдийн засаг Монголд хэрхэн нөлөөлөх вэ
- 34 “Эмэгтэйчүүд тэнгэрийн талыг дааж Явдаг”
- 37 Тавантолгойн нүүдэл

БИЗНЕС

- 40 Хямралыг хамтдаа давах ухаан
- 42 Азийн хөгжлийн загвараас бидэнд сурах зүйл бий юү?

ЭДИЙН ЗАСАГ

Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт энэ оны аравдугаар сарын байдлаар сарын 8869.8 сая ам.долларт хүрчээ. Үүнээс экспорт 3409.4 сая ам.доллар, импорт 5460.4 сая ам.доллар эзэлж байна. Гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеийнхээс 110.7 сая ам.доллараар буюу 1.3 хувиар өсчээ.



Дэлхийн эдийн засаг энэ онд 3.5 хувь, ирэх онд 3.9 хувиар өсөхөд дараах хоёр зүйл нөлөөлнө гэж Сангийн яамны мэргэжилтнүүд онцолжээ. Нэгдүгээрт, Евро бүсийн болоод дэлхийн санхүүгийн зах зээлийн байдал хөгжиж буй эдийн засгийн өсөлтийг удаашруулна. Хоёрдугаарт, Хятадын эдийн засгийн өсөлтийн



сааралт гол нөлөө үзүүлэх аж. Хөгжиж буй эдийн засагтай орнуудын өсөлт нь энэ онд 5.6 хувь, ирэх онд 5.9 хувь байх төлөв байгаа ч дээрх нөхцөл байдлаас хамаарч 0.1-0.2 хувийн өөрчлөлт орох магадлал бий аж.

ОХУ шатахууны экспортынхоо татварыг энэ сарын эхээр 6.4 хувиар нэмсэн бол төд удалгүй “Роснефть” Монголд нийлүүлэх импортын үнээ нэмсэн юм. Тухайлбал А-80 шатахуун тонн нь 1101 ам.доллар байсан бол 1133 болж, 32 ам.доллараар, АИ-92 шатахуун 44 ам.доллараар нэмэгдэж, 1345 болсон. Харин АИ-95 төрлийн шатахууны үнэд өөрчлөлт ороогүй байна. ОХУ-аас нийлүүлэх нефтийн үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан Уул уурхайн яамнаас энэ асуудлыг ойрын үед хэлэлцэж, шатахууны үнийг хэрхэх талаар арга хэмжээ авах зөвлөл шинээр байгуулна” гэжээ.

САНХҮҮ

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэн эхний үед гадаад орнууд, олон улсын байгууллагуудаас авсан албан ёсны тусламж ДНБ-ий 165 хувьтай тэнцэж байжээ. Энэхүү тусламж шилжилтийн үеийн хүндрэлийг давахад чухал үүрэг гүйцэтгэсэн



байна. Харин өнгөрсөн онд эдийн засаг өсөж, ДНБ 8.2 тэрбум ам.долларт хүрснээр хөгжлийн албан ёсны тусламж ДНБ-ий 2.3 хувьтай тэнцэх болсныг Сангийн яамны Төслийн санхүүжилт, зохицуулалтын газраас мэдээллээ. Өнөөдрийн байдлаар манайд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр нийт 1.6 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний 2.1 их наяд төгрөгийн 120 орчим төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа аж.

УУЛ УУРХАЙ

Эдийн засгийн хөгжлийн яамнаас танилцуулсан “Монгол улсын макро эдийн засгийн 2013 төсөөлөл”-д ирэх онд Оюутолгой төслийн олборлолт эхэлж, 556 мянган тонн зэсийн баяжмал экспортлоно гэж тэмдэглэжээ. Тус ордоос 2013-2016 онд 1.1-1.9 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэхээр төсөөлсөн байна. “Эрдэнэс Тавантолгой”




компанийн нүүрсний олборлолт ирэх онд хоёр дахин нэмэгдэхээс гадна бусад нүүрсний ордын зам, эрчим хүчний асуудал шийдэгдсэнээр нүүрсний олборлолт 35 саяд хүрэхээр төлөвлөсөн байна.


ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Үндэсний хөгжлийн хүрээлэнгээс гаргасан судалгаагаар Монгол улсад жилд дунджаар 34 мянга гаруй боловсон хүчин хөдөлмөрийн зах зээлд гардаг аж. Харин тэдний ердөө 40 хувь нь л ажлын байртай болдог байна.

ДЭД БҮТЭЦ



Богдхан уулын урдуур төмөр зам тавих “Богдхан төмөр зам” бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхээр боллоо. Төслийн хүрээнд УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Мандал-Багахангай өртөөг холбосон, Төв аймгийн Батсүмбэр, Алтанбулаг, Сэргэлэн,



Баян сумдын нутгийг дайран өнгөрөх нийт 170 км төмөр замын суурь бүтцийг шинээр барих юм байна. Төсөлд нийт 326.8 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд замыг 2016 онд ашиглалтад оруулахаар төлөвлөжээ.

ХЯТАД

Хятадын эдийн засаг энэ улиралд 7.4 хувь болж буурчээ. Гэсэн ч тус улсын



эдийн засагт сүүлийн үед сэргэлтийн шинж тэмдэг байгаа аж. Тухайлбал, Хонконгийн Nan Seng хувьцааны үзүүлэлт 0.7 хувиар өссөн бол Шанхайн хувьцааны ханш 1.2 хувиар нэмэгджээ. Түүнчлэн Тус улсын инфляци өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн ч өнгөрсөн наймдугаар сартай харьцуулахад хоёр хувиар буурсан үзүүлэлт юм.

ОРОС

Оросын “Роснефть” компани дэлхийн хамгийн том газрын тос үйлдвэрлэгч болохоор зэхэж

байна. Тус компанийн захирал Игор Сэчин Их Британийн үндэстэн дамнасан газрын тос, хий үйлдвэрлэгч TNK-BP компанийн 50 хувь хүртэлх хувьцааг худалдан авах гэж буй. Бэлэн мөнгө, хувьцаа нийлсэн 28 тэрбум гаруй ам. долларын энэхүү гэрээний нөхцөлд “Роснефть” компани 15-20 тэрбум ам.долларыг бэлнээр өгөх бол үлдсэн хэсгийг компанийн эзэмшлийн 10-20 хувьтай тэнцэх хувьцаагаар солихоор тусгажээ. Орос болон Их Британийн 50, 50 хувийн эзэмшлийн газрын тос, хий үйлдвэрлэлээрээ гуравдагч энэхүү компанийн хувьцааг худалдан авснаар “Роснефть” компани нь салбартаа голлох тоглогч болох юм.

ЯПОН



Япон улсын эдийн засгийн өсөлт дэлхийн томоохон улсуудын удаашралаас үүдэн энэ оны хоёрдугаар улиралд нэг хувиас 0.3 хувь хүртэл буурсан билээ. Тэгвэл тус улсын Ерөнхий сайд Ёшико Нода танхимын гишүүддээ дараа сар гэхэд эдийн засгаа сэргээх, улмаар хэвийн байдалд нь оруулах багц төлөвлөгөө гаргахыг үүрэгдсэн байна.

ЕВРОП

Европын дээд хэмжээнийн уулзалтаар Ахлах зөвлөхийн үүрэг гүйцэтгэж буй Европын Төвбанк Евро бүсийн 6000 банкны үйл ажиллагаанд шууд оролцох үүргийг хүлээх боллоо. Мөн ирэх оны нэгдүгээр сараас э Евро бүсийн эдийн засгийн интеграцыг түргэсгэх зорилгоор Банкуудын холбоо байгуулахаар болжээ. Эхний ээлжинд Испани улсын банкуудыг аврах бөгөөд аудитын шалгалтаар тус улсад эхний ээлжинд ойролцоогоор 77.4 тэрбум ам .доллар шаардлагатай гэ ойрын үедэн тооцоо гарчээ.

ТАРЬСАН МОД ХЭРХЭН НАХИАЛАХ БОЛ

И.ОТГОН

Европын өрийн хямрал, АНУ, Хятадын эдийн засгийн өсөлт удааширсан нь Монголд муу нөлөөтэй ч Монголын эдийн засгийн тулган дахь гал дүрэлзсэн хэвээр. Ирэх онд Монголын эдийн засаг хоёр оронтой тоогоор өссөн хэвээр байх урьдчилсан таамаг ч бий. Энэ удаа “Mongolian Economy” сэтгүүл санхүүгийн зах зээлийн мэдээллийг онцлон хүргэж байна. Монголын санхүүгийн зах зээл хөгжих үү, эс хөгжих үү гэдэг мөн л дотоодод төдийгүй гадаад зах зээлийн анхаарлын төвд орсон асуудал.

Дэлхийд коксжих нүүрсний нөөцөөрөө гайхуулж буй Тавантолгойн ордын ачаар монгол хүн бүр 1072 ширхэг хувьцаа эзэмшсэн. Холын ашгийг бодож хүн бүрт олгосон хувьцааг монголчууд хэдий болтол хадгалж, хэчнээн хэмжээний ашиг хүртэх нь тодорхой бус ч өнгөрсөн хавар тус хувьцааг тараах үед “Хувьцаагаа авах уу, Засгийн газарт зарах уу” гэдэг шинэ сонголттой тулгарсан. Хувьцаа эзэмшиж, ашиг хүртэх талаар туршлага багатай бидний хувьд том шийдвэр байв, энэ нь. Түүнчлэн Тавантолгойн иргэдэд эзэмшүүлсэн 1072 хувьцааны нэгжийн үнийг өмнөх Засгийн газар 933 төгрөгөөр тогтоосон. Бас болоогүй, 1.4 сая иргэн Засгийн газарт хувьцаагаа зарна гэсэн санал өгч амжсан. Өнгөрсөн тавдугаар сард чухлаар яригдаж байсан энэ асуудал дараахан нь сонгуулийн сүрд дарагдсан. Иргэдийн хувьд ч одоо болтол мөнөөх 1072 ширхэг хувьцаа яасан бэ гэж асууж сураглахгүй суугаа. Магадгүй энэ нь Тавантолгойн асуудлууд намдуу байгаа учраас тэр биз.

Мөн Монголын хөрөнгийн бирж, Лондоны хөрөнгийн биржтэй хамтарч ажиллах “Мастер” гэрээнд гарын үсэг зурсан нь жил хагасын өмнө олон улсын анхаарлыг татсан. Өнгөрсөн зун алдартай Millinium IT программаа ч ашиглалтад оруулсан. Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаа хэрхэн шинэчлэгдсэн бэ. Энэ асуултад мэдээж хариулт бий ч олон нийтэд

Монголын хөрөнгийн биржийн барилгын гаднах өнгө өөрчлөгдсөнөөс илүү тодорхой мэдээлэл одоо болтол алга байна. Гаднаас нь харахад, манай хөрөнгийн бирж аргагүй л Лондоны биржтэй хамтарч ажилласныг илтгэх мэт өнгө төрхтэй болсон. Өмнө нь улбар ягаан өнгөтэй байшин байсан бол өдгөө саарал өнгөтэй болж барилгын баруун доод буланд “Mongolian Stock Exchange” гэсэн алтан шаргал өнгөтэй хаяг хадсан нь тун догь. Дотроо үйл ажиллагаа нь хэрхэн шинэчлэгдсэн бэ гэдэг өнөөдөр таавар мэт. Шинэ программтай холбоотой арилжаанд оролцох брокер дилерийн компаниудын тоо уруудаж, өгсөж байна гэхээс илүү мэдээлэл олон түмэнд байхгүй. Хөрөнгийн биржээр үйлчлүүлдэг болон албан ажилтай хүмүүст бол мэдээж өөрчлөлт шинэчлэл мэдрэгдэж л байгаа байх.

Монголын санхүүгийн зах зээлд шинэчлэл үнэртүүлэх учиртай дараагийн нэгэн зүйл бол мөн л жил хагасын өмнө сүр дуулиантай үүдээ нээж, өрхөө татаж байсан Хөгжлийн банк юм. Уг хугацаанд үр ашиг өгөх дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх зорилготой Хөгжлийн банк байгуулагдсаны үр дүн гэж онцлохоор зүйл өнөөдөр төдийлэн харагдахгүй байгаа нь сонин. Олон улсын жишгээр бол санхүүгийн зах зээл дэх хөрөнгө оруулалтыг арилжааны банк, хөрөнгийн зах зээл нь тэнцвэртэй бүрдүүлж байх ёстой. Гэтэл Монголын санхүүгийн салбарын 95.6 хувийг банкны салбар дангаараа эзэлдэг бөгөөд үлдсэн 4.4 хувийг л үнэт цаасны зах зээл, даатгал зэрэг бусад салбарынхан эзэлж байгаа юм. Энэхүү гаж тогтолцоог өөрчлөх талаар яригдсаар байгаа ч бахь байдгаараа.

Монголын хөрөнгийн биржид тарьсан мод хэрхэн нахиалахыг цаг хугацаа харуулна. Хөрөнгийн захын дэд бүтцийн шинэчлэлээс гадна банк, даатгал зэрэг санхүүгийн бусад салбарт шинэчлэл үгүйлэгдэж буй. Хариу нэхсэн эдгээр асуудлын талаарх сонин сайхныг манай сэтгүүлийн энэ дугаараас унших боломжтой. ■

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ДАВААНЫ ЦААДАХ ДАВАА

Б.ЭНХЦЭЦЭГ

...Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, гадаадын хөрөнгө оруулагчдын хайрыг татах чухал алхам бол тус зэрэглэлд багтах. Тиймээс ирэх жилийн хөрөнгийн зах зээлийн өнгө төрхөөс их зүйл хамаарах нь...



Нэгэн цагт хөрөнгө мөнгөний булш хэмээн нүд үзүүрлэгдэж, гундуухан гэлдэрч явсан Монголын хөрөнгийн бирж хөлд бас хөлд орсон нь саяхан. Өдийг хүртэл хөрөнгийн биржийг сайн, муу хов жив салахгүй дагасан ч манай улсын хөрөнгийн зах зээлийн хөдөлгүүр ямартай ч ассан. Зарим улсыгн туршлагаас харахад арав гаруй жил бэлтгэж дэд бүтэц, хууль дүрмээ боловсруулан аажим аажмаар хөрөнгийн зах зээлээ хөгжүүлсэн байдаг. Харин манай улсын эдийн засгийн өсөлт бусад оронтой харьцуулахад гэрлийн хурд үзүүлэх болсон нь хөрөнгийн зах зээл бусдын жишгийг дагаж шинэчлэлээ үсэг үсгээр нь өрөх цаггүйджээ. Тиймээс дэлхийн улс орнуудын “Know How” гэж нэг сайхан будаа идэх арга байдаг даа. Цаг алдалгүйгээр хөгжлөө хөшүүрэгдэхийн тулд манай хөрөнгийн бирж бэлтгэл ажлаа нэг, нэгээр нь биш нэгэн зэрэг олны хүчээр шийдэхийг хичээсэн, хийж ч байгаа.

Энэ оны эхний есөн сард Монголын хөрөнгийн биржийн нийт арилжаа өнгөрсөн оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 1.3 дахин, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин өсөж, 142 тэрбум төгрөгт хүрчээ. Оны эхний хагаст өдрийн дундаж арилжааны хэмжээ 463 сая төгрөг байсан бол шинэ систем ашиглалтад орсноор өдрийн дундаж арилжаа 1.4 тэрбум төгрөгт хүрч өссөн үзүүлэлттэй байна. Энэ сарын байдлаар зах зээлийн нийт үнэлгээ нэг их наяд 786 тэрбум төгрөгт хүрчээ. Шинэчлэлээс өмнө хөрөнгийн биржийн арилжаанд 80-аад брокер дилерийн компани тогтмол оролцдог байсан. Харин шинэ системийг арилжаанд нэвтрүүлснээс хойш нэмэлт дүрэм журамтай нийцэх гэж багагүй цаг авсан брокер дилерийн компанийн тоо өнөөдөр 48 болжээ. Гэдээ энэ тоо цаашид нэмэгдэнэ. Манай улсад үйл ажиллагаа явуулдаг брокер дилерийн компанийн тоо »

▶ Тавантолгойн иргэдэд тараах хувьцаа, МХБ-ийн шинэчлэл гэх мэт сонирхол татсан асуудлаас үүдэн өнөөдөр 100 болтлоо өсөөд байгаа аж.

Манай хөрөнгийн бирж, Лондоны хөрөнгийн биржтэй хамтран Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд эрс шинэчлэл хийхээр санаа шулуудан 14 тэрбум төгрөгийн өртөг бүхий Мастер гэрээг 2010 онд үзэглэсэн билээ. Үүнээс хойш нэг жил зургаан сар өнгөрчээ. Хөрөнгийн биржийн шинэчлэл ямар үр дүн авчирч буйг асуух хүн олон байна. Учир нь Лондоны хөрөнгийн биржийн менежментийг Монголд нэвтрүүлэхтэй холбоотой Millennium IT систем гэдгийг монголчууд сайн тогтоосон. Олон улсын жишигт нийцсэн системийг сүр дуулиантай эхлүүлсэн шиг үр дүнг нь олон нийт мөн мэдэхийг хүсэж байна. Харамсалтай нь арилжаанд оролцогч брокер дилерийн компанийн тоо нэмэгдлээ гэхээс өөр мэдээлэл олны чихийг чимсэнгүй.

Монголын хөрөнгийн захын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилттой дээрх гэрээний гүйцэтгэл үр дүнгийн талаар холбогдох албаны мэдээллийг сонирхлоо. Гэрээний хүрээнд таван зорилт хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Технологийн шинэчлэлийг үндсэнд нь хийчихжээ. Дүрэм, журам зохицуулалтаа тодорхой хэмжээнд цэгцэлсэн байна. Ажил эхлэхээс дуусах хүртэл системийн найдвартай байдалд хяналт тавьж ирсэн гадаадын туршлагатай мэргэжилтнүүд ч чадах мэдэхээ монгол мэргэжилтнүүдтэй харамгүй хуваалцсан гэж үнэлж байна. Эдгээр мэдээллээс үзэхэд зах зээлийн хөгжлийн бөх бат суурь нэгэнтээ тавигдсан гэж хэлж болох нь ээ. Тэгвэл одоо юу дутуу юм бол. МХБ-ийн хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан Ү.Тэмүүжин “МХБ-ийн зүгээс гишүүн компаниудын эрсдэл даах чадвар, ёс зүйг дээшлүүлэхийн зэрэгцээ мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах тал дээр анхаарч ажиллаж байгаа” гэв. Мөн Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулж, зах зээлийн хөрвөх чадвар, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, бүртгэлтэй болон шинээр орж ирж буй компаниудаа чанаржуулах гэх мэт алхмыг шат дараатай



хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа аж. Хугацаа нь хараахан дуусгавар болчихоогүй байгаа Мастер гэрээний хүрээнд Лондоны хөрөнгийн биржтэй хамтран цаашид ахисан түвшний сургалт зохион байгуулах ажил бий гэнэ. Гэрээний хугацаа дууслаа гээд хөрөнгийн биржийн хөгжил, шинэчлэлийн хөдөлгөөн зогсчихгүйг холбогдох хүмүүс онцолж байлаа.

Өнгөрсөн сарын эцсээр олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгаагаараа тэргүүлэгч Их Британийн “FTSE групп” Монголын хөрөнгийн зах зээлийг “Хөгжиж буй” / Frontier Market/ зах зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын” жагсаалтад оруулсан гэдгээ мэдэгдсэн. Орнуудын хөрөнгийн зах зээлийг маш нарийн шалгууруудаар “Хөгжиж буй”-гаас “Өндөр хөгжсөн” хүртэл үндсэн дөрвөн зэрэглэлээр ангилдаг “FTSE групп” зэрэглэлээ жилд нэг удаа тогтоодог бөгөөд Монголын зах зээлийг ирэх нэг жилд ажихаар боллоо. Тус группын Засаглал, бодлого хариуцсан захирал Крис Вүүдс Монгол улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгө оруулагчдад нээлттэй болгох, дэлхийн жишигт нийцүүлэн хөгжүүлэх ажил богино хугацаанд өндөр амжилт гаргаж буйг мэдэгдэлдээ онцолжээ. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, гадаадын хөрөнгө оруулагчдын хайрыг татах чухал алхам бол тус зэрэглэлд багтах. Тиймээс ирэх жилийн хөрөнгийн зах зээлийн өнгө төрхөөс их зүйл хамаарах нь.

Хөрөнгийн захад үгүйлэгдэж буй институци

Засгийн газрын 2012-2016 мөрийн хөтөлбөрт банк санхүү, биржийн бүс нутгийн зангилаа төв бий болгох зорилт байдаг. Үүний тулд мэдээж өөрийн орны нөхцөлд тохирсон олон улсын жишгийг нэвтрүүлэх нь маш чухал. Хуулиас гадна олон улсын стандартад нийцсэн үнэт цаасны төлбөр тооцооны систем буюу хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц байх хэрэгтэй. Одоогоор манай хөрөнгийн зах зээлд хамгийн дутагдалтай дэд бүтцийн институци нь кастодиан банкны үйлчилгээ байгаа. Дотоодын хөрөнгө оруулагч бусад улсаас, гадаадын хөрөнгө оруулагч манайхаас хувьцаа худалдан авахад төлбөр тооцоо болон бусад мэдээллийг дамжуулах үүрэг бүхий байгууллага нь кастодиан банк. Манай зах зээл хэр тэлэхээс шалтгаалан энэ төрлийн банк хэд ч байж болно. “Хууль төдийгүй гаднын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, өмчлөх эрхийг найдвартай болгох шаардлагатай юм. Тиймээс ч СЗХ нэн түрүүнд кастодиан банкны журам дээр ажиллаж байна” хэмээн СЗХ-ны Үнэт цаасны газрын хянан шалгагч С.Цэвэгмид хэлсэн юм.

Арилжааны шинэ системтэй болсон нь сайшаалтай ч засаж, сайжруулах юм олон. Тухайлбал, Хөрөнгийн биржийн арилжаа олон улсын стандартын дагуу явж байгаа ч ▶



▶ төлбөр тооцооны систем чирэгдэлтэй хэвээр байгааг мэргэжилтнүүд хэлж байна. Хувьцааны төлбөр тооцоог ҮЦТТТХТ хариуцдаг бол үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөр тооцоог бусад оронд төлбөр тооцооны тусдаа байгууллагаар /Clearing house/ дамжуулдаг байна. Энэ нь арилжаа шуурхай явахад нэн тустай дэд бүтцийн институци аж. Худалдан авсан тал нь гурав хоногийн дотор хувьцаагаа, зарсан нь мөнгөө авах баталгааг дээрх байгууллага гаргаж өгдөг. Манайд тус баталгааг банкууд хангах болсон. Энэ нь нэгдүгээрт, харилцагчийн зардлыг нэмэгдүүлж хоёрдугаарт, явдал суудал их тул цаг хугацаа алдахад хүргэж байгаа аж. Төлбөр тооцоо хурдан хийгдэж байж Т+3 хугацаанд мөнгө дансанд орох үндэслэл бүрдэнэ. Брокер дилерийн “MWTS” компанийн гүйцэтгэх захирал Л.Энхтунгалаг “Мөнгөн төлбөр тооцоо хийх банкуудын нэгийг манай компанийн зүгээс сонгох болж байгаа. Гэтэл манай 40.000 харилцагч бидний сонгосон банканд дургүйцэх жишээтэй. Ялангуяа том харилцагч нарын хувьд арилжааны мэдээлэл тухайн банкаар дамжиж байгаа учир энэ асуудалд ихээхэн таагүй хандаж байгаа” хэмээв.

Хөрөнгийн зах зээлийн шинэчлэл хийгдсэнээр харилцагчид тэгш эрхтэйгээр нээлттэй үнэ хаялцан хувьцаа худалдан авах, улмаар зах зээл дээр бодит ханш тогтох боломж гарч ирлээ. Хөрөнгийн зах зээл бол хөрөнгө оруулалтыг үр ашигтайгаар

татах хүн төрөлхтний шалгарсан арга гэдэг. Олон улсын сүлжээнд холбогдож, үндэстэн дамнасан арилжааг хийх боломж бүрдэнэ гэдэг маш том алхам гэдгийг мэргэжилтнүүд ч өндрөөр үнэлж байгаа. Гэхдээ хууль, эрх зүйн орчин тодорхой бус байдал нь хөгжлийг хойш татна. Тиймээс ч Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулга санхүүгийн салбарынхныг нүдээ чилтэл харж суугаа ганц гацаа. Тус хуулийг дахин хянаж, нарийвчлах шаардлагатай гэж үзээд, Хууль зүйн яаманд буцаасан аж. Үнэт цаасны тухай хууль одоо хөрөнгө босгох гэж байгаа компаниудын хувьд тийм их хамааралтай биш ч энэ чигээрээ удвал хувьцаа, бондоос гадна хөрөнгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн гаргах мөн институционал хөрөнгө оруулагч зах зээлд орж ирэх боломжгүй юм. МХБ-ийн ТУЗ-ын гишүүн Ө.Ганзориг “Монголын санхүүгийн зах зээл 22 жил хуульгүй явлаа. Хууль хэрэгтэй болохоос төгс хууль хэрэггүй. 2012 он гарчихаад байхад даатгалын компаниуд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах эрхгүй байгаагаас гадна хөрөнгө оруулалтын сангуудын тухай хуулийн төсөл ч алга. Арилжаа хийх хүмүүсийг бий болгохын тулд хуулиудаа л хурдан гаргах хэрэгтэй” хэмээн учирлаж байв.

Хөрөнгийн зах зээлийн хөгжих гарц

Сүүлийн жилүүдэд IPO хийх компаниудын тоо ихсэх хандлагатай болсон. Цаашид ч цөөнгүй компани хөрөнгө босгохоор төлөвлөж байгаа нь хэдэн жилийн өмнөхтэй харьцуулахад хөрөнгийн зах зээлд их хэмжээний хөрөнгө босгох боломж байгааг илтгэж байна. Эдийн засагч Д.Жаргалсайхан “Монгол улсын ДНБ энэ жил 10 тэрбум ам.доллар болох гэж байна. Нийт 10 тэрбум ам.долларын үнэт зүйл бүтээж байгаа улсад дахиад ийм хэмжээний хөрөнгийн зах зээлтэй байх боломж бий” хэмээн хэвлэлд өгсөн ярилцлагадаа онцолсон билээ. Хөрөнгийн захыг хөгжүүлчихвэл компаниуд зөвхөн банкнаас зээл хүсээд зогсох бус хөрөнгийн зах дээр хувьцаа, бондоор дамжуулан санхүүжилт авах боломжтой. Гэвч

хөрөнгө босгох боломж ярихаас өмнө үнэт цаас буюу бүтээгдэхүүнээ чанаржуулах ёстойг мэргэжилтнүүд хэлдэг. Брокер дилерийн “Тэнгэр Капитал” компанийн хөрөнгийн зах зээл хариуцсан дэд захирал Б.Дөлгөөн “Хөрөнгийн биржийн өөрийн хүлээс арилсан бол одоо хөрөнгө оруулагчдыг татах, нөгөө талаас чанартай сайн бүтээгдэхүүн буюу үнэт цаас гаргах компаниудыг ятган, оруулж ирэх хэрэгтэй. Ингэвэл томоохон хөрөнгө оруулагчид ч сонирхоно” хэмээв. Хөрөнгийн зах зээлийн томоохон тоглогчид нь бүх төрлийн хуримтлал, төрийн сангууд байдаг. Бусад оронд даатгал, эрүүл мэндийн сан нь хөсөр хэвтэх биш хөрөнгийн зах зээлдээ эргэлдэж байдаг. Гэтэл өнөөдөр манай нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал нэрээр хуримтлагдсан мөнгө хаана байгаа нь ч тодорхойгүй. Үнэт цаасны тухай хууль ил тод байдлыг нэхэх нэг хөшүүрэг учир тус хууль батлагдсан цагт энэ бүхэн тодорхой болох нь дамжиггүй. СЗХ-ны Үнэт цаасны газрын хянан шалгагч С.Цэвэгмид “Хөрөнгийн зах зээл гол нь мэдээлэл дээр суурилдаг. Манай хувьцаат компаниуд мэдээллээ нээлттэй болгох /disclosure/ тал дээр хангалтгүй байна. Энэ тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагааг сайн мэддэг хүн эсвэл хувьцааны үнэ ханшийн хөдөлгөөнөөс ашиг хийх гэсэн нөхдүүд үнэт цаасны арилжаанд оролцоно уу гэхээс гадаадын болон дотоодын мэргэшсэн хөрөнгө оруулагч үнэт цаасны үнэлгээ хийгээд хөрөнгө оруулах ямар ч боломжгүй гэсэн үг” хэмээн тайлбарлав. Чанар, стандарт хангасан эсэхийг шалгаж, үнэлэх хэмжээнд ил тод байна гэдэг бүтээгдэхүүний чанарыг илтгэх нэг үзүүлэлт. Ингэхээр мэдээлэл хаалттай байх аваас хөрөнгө оруулагч нэг нүдээрээ ч тоож харахгүй нь.

Хөгжиж буй орнуудад гарц олон байхын хажуугаар гацаа үүсэх нь их. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг шийдлээ гээд бүх зүйл санаснаар болохгүй нь мэдээж. Шинэхэн, дэд бүтцээ ашиглаж, үйлчлүүлэгчдээ олох гээд хэл, хөлд дөнгөж ороод буй Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд давааны цаадах даваа олон байна. ■

АСУУДАЛ

“ЛОМБАРДАНД” БУЙ МОНГОЛ УЛС

Б.ЭНХМАРТ

...Засгийн газар гаднын улсаас зээлсэн мөнгөө халамж, тэтгэмж, хандивт юүлээд, өглөгч царайлаад байвал хямрахын дохио юм. Үүний тод жишээ бол “Эрдэнэс Тавантолгой” компани намуудын сонгуулийн амлалтыг биелүүлэх нэрийн дор БНХАУ-ын төрийн өмчит “Чалько” компанид нүүрсний нөөцөө “ломбардаж”, 250 сая ам.доллар зээлж, ард түмэнд “Хүний хөгжил сан” хэмээх сайхан нэрийн дор тараасан явдал...

8.6 их наяд төгрөг. Энэ бол манай улсын гаднынхнаас зээлсэн мөнгө. Өнгөрсөн оны төсөвт энэ оны өрийн хэмжээг ДНБ-ий 47.7 хувьтай тэнцэнэ, энэ үед эдийн засгийн өсөлт 25.6 хувьд хүрсэн байна хэмээн тодотгож байсан. Тэгвэл өнөөдөр эдийн засгийн өсөлт 13.2 хувьтай явж байгаа. Төсвийн алдагдал ДНБ-ий 4.8 хувьтай тэнцэж байгаа бөгөөд Засгийн газар энэ алдагдлаа бонд гаргаж, нөхөхөөр болоод буй.

Монгол улсын Засгийн газар төсвийн алдагдлаа гаднын улсууд, Хөгжлийн банкуудын хөнгөлөлттэй зээл, тусламжаархаасаарирсэн. 1990-ээд оноос хойш манайх нийт дөрвөн тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээл, тусламж, авсны 28 хувь нь Азийн хөгжлийн банкинд, 20 хувь нь дэлхийн банкинд, мөн хэмжээний хувь нь Японы Засгийн газарт ногдож байна. Тэр ч бүү хэл, Монголын Засгийн газрын бондыг дотоодын банкуудад зарсан, байгуулсан сангаасаа зээл авч халамжид нэг тэрбум ам.доллар тараасан билээ. ДНБ-ий 47.7

хувьтай тэнцэж буй өрийг эдийн засагт дарамт учруулах хэмжээний асуудал биш гэх эдийн засагч байхад “Монгол өрөндөө баригдаж, өтөндөө идэгдээд байна” хэмээн бухимдах хүн ч байна. Түүнчлэн өрийн хэмжээг 8.6 их наядаас илүү байх вий хэмээн болгоомжлох хүн ч цөөнгүй. Учир нь зээлийн хугацаа хийгээд, нөхцлөөсөө хамаарсан хүүгийн хүү, богино хугацаанд бэлэн мөнгө болон орж ирчихээд, урт хугацааны гарлага болон үлддэг бонд зэрэг нь цаг, минутаар өрийн хэмжээг зузаатгаж байдгийг эдийн засагчид онцолдог.

Хэдэн тэрбум ам.доллараар нь зээлчихээд жилд 10-12 сая ам.долларыг гадаад өрөнд төлж, барагдуулж байгаа хэмээн албаны хүмүүс ярьж байгаа нь ирээдүй хойч үедээ өрийн авдар хадгалж буйн илрэл гэлтэй. Гадаад өрийн хэмжээ ДНБ-ий 40 хувиас хэтрээд ирвэл эдийн засгийн хямрал төдийгүй, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрдэг гэдэг. Харин манай Сангийн яамны мэргэжилтнүүд,

Монголбанкны түшмэлүүд “Гадаад өр зохист хэмжээнээс хэтрээгүй, нэг үгээр үндэсний аюулгүй байдалд заналхийлэх хэмжээнд очоогүй. Нэг үе манай улсын гадаад өр ДНБ-ий 90 хувийг эзэлж байсан. Тэр л жинхэнэ түгшүүр байсан. Одоо бол Монголын эдийн засаг энэ зэргийн өрөөс айхааргүй болсон” гэх хариулт өгсөн юм. 2020 оноос манай улсын зээлийн эргэн төлөлтийн дарамт одоогийнхоос хоёр дахин нэмэгдэнэ хэмээн олон улсын шинжээчид анхааруулж буй.

Өрийн галт тэрэг хөдлөхөд бэлэн

Хэдийгээр өнөөдөр үүсээд байгаа гадаад өрийн хэмжээ төсвийн Тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасан үзүүлэлтийг хангаж буй ч үүнд санаа амарч болохгүй. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн буцаан төлөлтөөр энэ онд үндсэн төлбөрт 34.5 тэрбум, хүүгийн төлбөрт 9.6 тэрбум, нийт 44.1 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэх учиртай. Монголын Засгийн газар хандивлагч орнууд болон олон улсын санхүүгийн байгууллагаас энэ онд 708.1 тэрбум, ирэх онд 180 тэрбум, 2014 онд 200 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийг гаднынхнаас зээлэхээр төлөвлөөд байгааг Сангийн яамныхан хэлж буй. Зөвхөн энэ онд л гэхэд Засгийн газрын гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт 111.2 тэрбум, бондын хүүгийн төлбөрт 167.4 тэрбум төгрөг төлөх ёстой. Үүний дээр Засгийн газар дөрвөн хувийн хүүтэй ▶



▶ таван тэрбум ам.доллар буюу долоон их наяд төгрөгийн бонд гаргахаар болчихлоо. Одоохондоо үүнийг ерд тооцохгүй гэсэн. Уг нь манайх АНУ, ХБНГУ, Франц, Грек зэрэг оронтой барьцаж, бүгдийг бондоор шийдэх цаг нь болоогүй, туршлага нь түүхийгээрээ байгаа. Өмнө нь гаргасан бондын үр дүнгээс үүнийг бид харах ёстой байсан юм. Засгийн газрын өмнөх бондууд хийгээд 2011 онд гаргасан бондын үндсэн төлбөрт энэ онд 189.9 сая, ирэх онд 154 сая 2014 онд 86 сая төгрөгийг төлөхөөр байсан юм. 2012-2014 онд нэмж бонд гаргаагүй тохиолдолд шүү дээ. Гэхдээ галт тэрэг нэгэнт хөдөлчихлөө. Тэр ч байтугай Улаанбаатар хотын бонд гаргах тухай ч ярьж эхэллээ. Бондын талаар эдийн засагч, нийтлэлч Д.Жаргалсайхан “Засгийн газар нь

бондоо олон улсын зах зээл дээр гаргах нь тухайн орон хөлөг онгоцоо том далайд гаргаж байгаатай адил хэрэг. Аль нэг улсын Засгийн газар 10-30 жилийн хугацаатай өрийн бичгээ гадаадын зах зээлд гаргахыг бие даасан улсын өр (sovereign bond) гэдэг. Хувь хүн биш, хувийн компани биш, өөрөө татвар цуглуулж чаддаг Засгийн газар нь гаргадаг учир хөрөнгө оруулагчид өрийн бичгийг нь худалдан авч хугацааны эцэст гаргасан хөрөнгөө хүүгийн хамт эргүүлэн авдаг” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь нэг талаар банкны барьцаатай зээл, ломбардны үйлчилгээтэй төстэй юм. Засгийн газраар хамгаалагчаа хийсэн бондын галт тэргийг зогсоох боломж бараг үгүй гэж болно. Энэ нь Засгийн газар хоосон хэтэвчээ “юм”-тай болгох гэж

таван тэрбум ам.долларын бондын өр тавихаар сэтгэл шулуудсан гэсэн үг. Тиймээс эх орноо барьцаалан байж ирэх мөнгийг хэрхэн үр өгөөжтэй зарж, өсгөх вэ гэдэгт анхаарлаа хандуулах зарцуулалтыг хянах хэрэгтэй. Зээлсэн, босгосон мөнгө бүхэн үржиж, өрөө төлөхөд эргэлтийн мөнгө халаасанд үлдэж л байвал бид үр хойчдоо өр биш, бүтээн байгуулалт, арвин туршлага үлдээх юм. Үүний тулд яах ёстой вэ?

Үржүүл эс бол бүү зээл

Хэн нэгнээс мөнгө зээлчихээд “Өрөө яаж төлөх вэ, одоо би яана” гэж бодоод, идээд, хэвтээд байвал зээлсэн мөнгө өр болоод л үлдэнэ. Харин хэрхэн үр өгөөжтэй, бага юмнаас том ашиг унагах вэ гэдэгт төвлөрч, идэж уух, өмсөх зүүх, амарч зугаалах бус эргээд ашиг болох зүйлд зарцуулсан нь баяжина. Засгийн газар гаднын улсаас зээлсэн мөнгийг халамж, тэтгэмж, хандивт юүлээд, өглөгч царайлаад байвал хямрахын дохио юм. Үүний тод жишээ бол “Эрдэнэс Тавантолгой” компани намуудын сонгуулийн амлалтыг биелүүлэх нэрийн дор БНХАУ-ын төрийн өмчит “Чалько” компанид нүүрсний нөөцөө “ломбардаж”, 250 сая ам.долларыг зээлж, ард түмэнд “Хүний хөгжил сан” хэмээх сайхан нэрийн дор тараасан явдал. Энэ нь хүнээ хөгжүүлсэн ч юмгүй, хүн нь хөлжсөн ч юмгүй ашиггүй өр болоод үлдсэн. Үүнээс гадна төмөр зам зэрэг томоохон бүтээн байгуулалт хийхээр олон улсын зах зээл дээрх жилийн 5.75 хувийн хүүтэй босгосон 580 сая ам.доллар Хөгжлийн банкны дансанд сайн төсөл хүлээн, өдрийн 91 мянган ам.долларын хүү хий төлж байгаа билээ. Энэ мэт уул уурхай хийгээд байгалийн баялгийг барьцаалсан ашиггүй өр зээл, өглөг хандив, төсөл манайд цөөнгүй хэрэгжиж буй. Байгаа баялгаа өгөөд ч өртэй үлдвэх вий гэх айдас олон хүнд байна. Ашиг авчрахгүй, үржүүлж чадахгүй, үр хойчийг өр төлбөрт унагасан зээл тавихаас Монгол улс эмээдэг байгаасай.

Зээл, зээл бас дахин зээл

Монголбанкны гаргасан мэдээл-лээр нийт гадаад өрийн 3.2 тэрбум ▶▶

► нь Засгийн газрын, 275 сая нь Төвбанкны, 609 сая нь арилжааны банкуудын, 4.3 тэрбум нь аж ахуйн нэгж, иргэдийн нэр дээр байгаа гэнэ. Аж ахуйн нэгж, хувийн байгууллагын нэр дээр байгаа гадаад өрийн дийлэнх нь шууд хөрөнгө оруулалт гэсэн тодотголтойгоор монголчуудыг “өрөнд” оруулсан байна. Шууд хөрөнгө оруулалт гэх халхавчтай боловч энэ нь хэзээ нэгэн цагт эргэн төлөх өр байдгийг хэн хүнгүй мэддэг. Тэгсэн хэрнээ өнөөгийн гадаад өрийн дийлэнхийг энэ нэр томъёо эзэлж байгаа нь харамсалтай. Гэхдээ өрийн хэмжээ нэмэгдэнэ гэдэг тухайн улсын орлого олох чадварыг илтгэдэг учраас энэ нь бас муу зүйл биш юм. Том эдийн засагтай улс орнуудын гадаад өр ДНБ-ийхээ 70 хувиас давсан байх нь энгийн үзэгдэл аж. Учир нь тэд өрийг их, багаар нь бус хэр өгөөжтэй, бүтээмжтэй байгаагаар нь дүгнэдэг гэнэ. Дэлхийн даяаршсан өр өнөөдөр 210 их наяд ам.долларт хүрч, цэнхэр гаригийн ДНБ-ий хэмжээнээс гурав дахин их болжээ. Их гүрнүүд том өрнөөс айхгүй байна. Дэлхийн эдийн засгийн судалгааны “FOREX CLUB” төвөөс дэлхийн хамгийн их өртэй орнуудыг зарлахад, тэдний хэн нь ч сандардаггүй. Харин ч нэмж зээл, төсөл, хөтөлбөрүүдийг өгнээндээ нэгтгэсээр. Энэ нь өр бол айдас биш гэдгийг нотолж байх шиг. Гэхдээ аливаа өрийг болгоомжтой, зөв зарцуулахгүй бол Евро бүс хийгээд Азийг эдийн засгийн хямралд чирч буй Грекийн араас орохгүй гэх үндэсгүй юм.

Дэлхийн хамгийн их өртэй эхний таван улс,

Улсын нэр	Өрийн хэмжээ /ам.доллар/	ДНБ-д эзлэх хувь
Япон	-	211
Грек	-	132
АНУ	17 их наяд	103
Франц	2.4 их наяд	87
ХБНГУ	2.9 их наяд	80
Монгол	8.1 тэрбум	47.7

Хугацаа чухал

Урд хөрш нийт 785 тэрбум ам.долларын өртэйгээс 75 хувийг нь богино хугацааны зээл эзэлдэг тухай “Синьхуа” агентлаг мэдээлсэн. Харин АНУ болон Европын холбооны улсуудын өрийн ихэнхийг урт хугацааны зээл эзэлдэг. Монголын арилжааны банкуудын зээлийг авч үзвэл холимог байдалтай байна. Гэхдээ хүү өндөр, богино хугацааны зээл давамгайлах талдаа. Харин банкны салбарын гадаад өрийн 85 хувь нь урт хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй, үүний 35 хувь нь бонд буюу өрийн бичиг хэлбэрээр, 28 хувь нь арилжааны зээлийн хэлцэл, 11 хувь нь харилцах, хадгаламжаар, үлдсэн 10 хувь нь тусламж аж. Эдийн засагчид богино хугацааны зээл ашигтай, урт хугацааны зээл удаан хугацааны тогтвортой бодлого, боловсруулалт шаарддаг учраас туршлагагүй улс орон хийгээд хүмүүст эрсдэл авчирна гэж үздэг. Урт хугацааны зээлийг ядуу болон хөгжиж буй оронд хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг тухай ч ярьдаг. Гэхдээ ашигтай тал нь хүү багатай, төлөх мөнгөн дүн хугацаанаас хамаарч бага тусдаг. Энэ нь өнөөдрийн Монголд илүү ач тустай боловч хэрэглээний зээлийн ихэнхийг өндөр хүүтэй, богино хугацааны зээл эзэлж байгаа юм. Тэгээд ч Монголд үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны 14 банкинд урт хугацаанд ямар нэг төслийг дэмжиж, их хэмжээний зээл олгох хуримтлал байхгүй. Тиймээс өөрсдийн ашиг хийгээд эргэлтээ бодож, богино хугацааны зээл олгох боломжтой байдгийг Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч Ян Хансэн ярилцлагадаа дурджээ.

Шүхрээ бэлдэцгээ

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Татварын ерөнхий газрын цахим хуудаснаа татварын өртэй татвар төлөгчдийн нэрсийг байршуулсныг хүснэгтээс харна уу.

Монголын хамгийн их өртэй эхний таван компанийг жагсаавал, /төгрөгөөр/

1.	Эм Жэй Эйч ХХК	11062186.1
2.	Алтандорнод монгол ХХК	9754142.5
3.	Жамп ХХК	6739989.8
4.	Монгол газар ХХК	2878476.6
5.	Эрдэс холдинг ХХК	2133829.0

Татварын газар, хэлтсээр өрийн хэмжээг харуулбал, /төгрөгөөр/


Улсын төсвийн орлого, хяналтын газар	21712941.8
Нийслэлийн татварын газар	2969431.9
БГД-ийн татварын хэлтэс	40668.0
БЗД-ийн татварын хэлтэс	464414.7
СБД-ийн татварын хэлтэс	8211314.3
СХД-ийн татварын хэлтэс	208707.7
Хан-Уул дүүргийн татварын хэлтэс	298165.7

Эх сурвалж: ТЕГ

Харин энэ оны хоёрдугаар улирлын эцсийн байдлаар Монголбанк болон банкуудын Засгийн газраас авах авлага 702 тэрбум төгрөгт хүрчээ. Банкны системийн Засгийн газраас авах авлагын 45.4 хувийг Төвбанк, 54.6 хувийг арилжааны банкууд эзэлжээ. Гаднынханд тавьсан өр ч яахав, өгөх нь тодорхой. Харин дотоодын компани, аж ахуйн нэгжүүдээс авах авлагаа түргэн татах цаг ирж байна. Учир нь Евро бүс хийгээд Азийн томоохон эдийн засгийг хамарч эхэлсэн эдийн засгийн хямралын салхи манайд аль хэдийнэ исгэрч эхэлсэн. Энэ салхи хоёр сар гаруйн дараа айлчлах шинэ оноос шуурга болж мэдэх таамаглалыг олон улсын шинжээчид дэвшүүлж буй. Дэлхийн улсууд зарлагаа хумьж, хуримтлал үүсгэхэд анхаарч, “Зөвхөн хуримтлал” гэсэн уриа үг ч гаргаад байгаа. Ийм үед монголчуудад халаасан дахь мөнгө нь аадраас хамгаалах шүхэр болох учиртай. Түүнээс биш, харийнхны мөнгийг хадгалахын зэрэгцээ хүүний өрөнд унах нь зөв сонголт биш юм. Муухайгаар хэлбэл бид өнгөрсөн хэдэн жилд эх орноо “ломбарданд” тавьчихаад, “Эдийн засаг өслөө” хэмээн эндүүрч суусан билээ. ■

ТООН МЭДЭЭ

Монгол улсын гадаад өрийн талаарх тоон мэдээллийг сонирхоно уу.




Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл/экспорт/

Он	Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл	Экспорт
2000	576.8	919.6
2001	572.4	936.5
2002	581.8	1,108.10
2003	719.2	1,448.80
2004	1,033.60	1,644.40
2005	1,270.00	1,601.40
2006	1,819.70	1,647.90
2007	2,210.20	1,788.40
2008	2,969.20	2,013.80
2009	2,741.30	2,609.00
2010	2,741.30	2,209.60
2011	6,234.10	2,669.40
2012	7,522.10	2,750.80


Гадаад өрийн дунд хугацааны төсөөлөл

Үзүүлэлтүүд	2013 он	2014 он	2015 он
Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл	3,236.3	3,850.7	4,242.7
Гадаад зээлийн ашиглалт (ГЗА)	572.5	703.7	477.4
Гадаад зээлийн үндсэн төлбөр (ЗҮТ)	87.0	89.3	85.4
Гадаад зээлийн хүүгийн төлбөр (ЗХТ)	27.5	28.7	26.7
Гадаад өрийн үйлчилгээний төлбөр (ӨҮТ)	114.5	118.0	112.1


Зээл олгогч улс, байгууллагууд



Хандивлагч, Олон улсын санхүүгийн байгууллагад тавих гэж буй өр /тэрбум төгрөгөөр/



Засгийн газрын гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийн хуваарь /тэрбум төгрөгөөр/



Засгийн газрын гадаад өрийн төгрөгтэй харьцах валютын ханшийн таамаглал валют /жилийн эцсийн байдлаар/


	2011	2012	2013	2014
Ам.доллар	1223.1	1177.1	1132.8	1090.3
Евро	1824.7	1829.2	1686.0	1544.6
Юань	202.0	202.6	215.7	228.8
Иен	15.5	15.6	15.2	14.8
Вон	1.15	1.15	1.13	1.11
Рубль	43.2	43.3	42.2	41.0

Улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2013 он	2014 он	2015 он
Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Улсын өр (ӨҮЦ)-ийг ДНБ-д харьцуулсан харьцаа болох өрийн дээд хязгаар	50%	40%	40%
Улсын өр (ӨҮЦ) ДНБ	46.1%	42.1%	40.5%
Гадаад зээлийн үлдэгдэл (ӨҮЦ)/ДНБ (дээд хязгаар 40%)*	31.8%	33.4%	32.5%
Улсын өр (ӨҮЦ) Экспорт (дээд хязгаар 150%)	58.4%	54.1%	61.3%
Улсын (ӨҮЦ) өр/ Засгийн газрын орлого (дээд хязгаар 250%)	114.5	118.0	112.1
Өрийн үйлчилгээний төлбөр /Экспорт (дээд хязгаар 20%)	0.8%	0.6%	0.5%
Өрийн үйлчилгээний төлбөр /Засгийн газрын орлого (дээд хязгаар 30%)	1.6%	1.3%	1.0%
Өрийн үйлчилгээний төлбөр /Засгийн газрын зарлага (дээд хязгаар 25%)	1.5%	1.4%	1.3%

*ОУВС /ДБ-аас тогтоосон өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлт


Зээлийн үйлчилгээний төлбөрийн төсвийн орлоготой харьцах хувь




Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл-харъяаллаар

Монголбанкны зээл	-152.0 тэрбум
Засгийн газрын үнэт цаас	-455.7 тэрбум
4.000 орон сууц хөтөлбөр	-84.0 тэрбум
Банкны бүтцийн өөрчлөлт	-60.0 тэрбум
Ноос, ноолуур, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих	-221.6 тэрбум
Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх	-89.7 тэрбум
Нийт	607.4 тэрбум


Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдлийг салбарын ангиллаар авч үзвэл



Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл /өмчийн ангилалаар



Засгийн газрын 2012-2014 онуудын гадаад өрийн эргэн төлөлтийн төсөөлөл /төгрөгөөр



БАНК

ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ

Б.БАЯРТГОТХ

...Дэлхийн банкны судлаач Н.Мөнхнасан “Хөгжлийн банкны засаглал сул байна” гэж дүгнэсэн юм. Тэрбээр засаглалд хуулиас хүчтэй улс төрийн эрх мэдэл давамгайлж байгааг онцолсон билээ...

Төрөөс үүсэлтэй санхүүгийн гурван сектор бий. Төвбанк, Хөгжлийн банк, Төрийн банк. Эдгээр банк нь Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, мөнгөний бодлогыг зохистой түвшинд авч явах санхүүгийн цөм. Өөрөөр хэлбэл, гал алдах цагт Төвбанк аминд орж, амар жимэр суух үед Төрийн банк, Хөгжлийн банкаар дамжуулан “хөгжлийн модоо усалдаг” гэсэн үг. Гэхдээ дээрх гурван банкны үйл ажиллагаа, үндсэн чиглэл, зорилт нь өөр өөр. Төрийн банк нь цэвэр ашгийн төлөө буюу арилжааны шинж чанартай бол Төвбанк нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах үндсэн үүрэгтэй. Хөгжлийн банкны хувьд үр ашиг багатай, урт хугацаанд хэрэгжих бүтээн байгуулалтыг санхүүжүүлнэ гэсэн эрс тэс байр сууринаас асуудалд ханддаг. Засгийн газар болон УИХ-аас баталсан тогтоол, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах эрх бүхий Хөгжлийн банкны засаглал сул байгааг Дэлхийн банкны судлаач Н.Мөнхнасан энэ сарын 12-нд болсон МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс зохион байгуулсан “Монголын эдийн засгийн

бодлогын асуудлууд” хурлын үеэр хэллээ. Тэрбээр “Хөгжлийн банк төсвөөс гадуур асар их зарлагыг санхүүжүүлж байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн ач холбогдолыг доголдуулж байна” гэв.

Хөгжлийн банкны 600 сая ам.долларын зээл нь Монгол улсын дотоодын хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх бөгөөд ДНБ-ий зургаан хувьтай дүйж байна. Мөн Хөгжлийн банкны оруулж буй төслийн ихэнх нь орлого авчирдаггүй, цаашдаа төсвийн санхүүжилт шаардахаар байгааг Дэлхийн банкныхан онцолсон юм.

Зөвхөн замын төсөлд л гэхэд дангаар 700 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт шаадлагатай аж. “Хөгжлийн банкны хуульд олон сул тал байна. Нэгдүгээрт, үйл ажиллагаандаа зардлаа нөхөх зарчимтай тодорхой заалт байхгүй. Санхүүжүүлэх төслийг сонгоходоо Засгийн газар, УИХ-ын эрх мэдэл шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Засгийн газраас хангалттай хараат бус, биеэ дааж чадахгүй байна” гэж судлаач Мөнхнасан тайлбарласан юм.

Дэлхийн хөгжингүй орнуудын Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 12-30 хувь байдаг бол манайх зургаан хувь байгаа аж. Мөн Хөгжлийн банкны хяналт шалгалтын чиг үүрэг тодорхой бус. Монголбанкинд гүйцэтгэх тодорхой үүрэг нь байдаггүй болохыг ч Дэлхийн банкны судлаач тэмдэглэлээ. Тэрбээр манай улсын хувьд эрдэс баялгийн нөөцийн боломжийг тогтвортой хөгжилд чиглүүлэх том сорилт тулгарч байгааг өгүүлсэн. Одоогийн босгосон 600 сая ам.доллар төмөр зам, орон сууц, боловсруулах үйлдвэр барих хангалттай хөрөнгө биш. Зөвхөн эхлүүлэх хэмжээнийх аж. “Хөгжлийн банкинд ирэх онд нэмж эх үүсвэр шаардагдана. Гэхдээ одоогийн байдлаар ирэх онд ямар хэмжээний бондыг хэдий хугацаатайгаар аль зах зээлд гаргах, мөн өөр ямар эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэх үү талаар төлөвлөгөө хараахан гараагүй байна” гэж тус банкнаас тайлбарласан юм.

Хөгжлийн банкны хөрөнгөжих Хөболцоонь бонд, монголчуудын хөгжих гарц нь бондоос үүссэн мөнгөн хөрөнгө. Тэгвэл үүнийг захиран зарцуулах эрхийг Хөгжлийн банк Засгийн газар, УИХ-аар дамжуулан эзэмшиж байна. Гэтэл Монгол улсын Хөгжлийн банкны Тэргүүн дэд захирал хэн болох вэ гэсэн асуулт хариулт нэхсээр даруй гурван сарыг үдэх гэж байна. Мэдээж, Монгол хүн Тэргүүн дэд захирал нь болно. Тус банкны өдөр тутмын үйл ажиллагааг ▶

► удирдах, бодлогын асуудлыг Гүйцэтгэх захиралтай зөвшилцөх, шаардлагатай тохиолдолд дангаар бие даан шийдвэр гаргах эрх бүхий тус албыг улстөржүүлэх бус улсаа хөгжүүлэхэд анхаарах учиртайг тус банкны ТУЗ-ийн гишүүд учирлаж байсан юм. Тиймээс тус банкны Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-өөс Тэргүүн дэд захирлыг сонгон шалгаруулах тендерийн шалгуурт тэнцэх хэд хэдэн хүн холбогдох бичиг баримттай танилцсан байна. Өнгөрсөн хугацаанд Хөгжлийн банкны ТУЗ дөрвөн удаа солигдсон. Хамгийн сүүлчийнх нь Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэх Б.Шинэбаатараар ахлуулсан шинэ ТУЗ болж байна. Эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд О.Чулуунбат “Өнгөрсөн хугацаанд яам болгон өөрийнхөө салбарын төсөлд хөрөнгө оруулалт хийх гэж зүтгэсээр ойлголцож чадаагүй. Үүнээс болоод Хөгжлийн банкаар дамжуулан босгосон хөрөнгийг ашиглаж чадахгүй байгаа юм. Харин Эдийн засгийн хөгжлийн яаманд манай салбар гэсэн сонирхлын зөрчил байхгүй учраас төслүүдийг жинхэнэ эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлнэ. Улмаар хамгийн түрүүнд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай бэлэн төслүүдийг Засгийн газарт танилцуулна” гэж хэлсэн удаатай.

Улаанбаатар хотын зам бүдрэх нүх, тойрох хагархай, цоорхойгүй болж буй нь Хөгжлийн банкны “цуутай” хөрөнгийн өгөөж юм байна. Тус банкнаас одоогийн байдлаар 337 тэрбум төгрөгийн санхүүжилтийг дэд бүтэц, цементийн үйлдвэр, орон сууцны зээлийн эх үүсвэрт зарцуулаад байгаа аж. Тодруулбал, нийслэлийн замын төсөв 117 тэрбум, орон нутгийн зам 660 тэрбум төгрөгийн өртөгтэй. Тус хөрөнгийн хүрээнд хотод 17, орон нутагт 13 төсөл хэрэгжүүлж байгаа аж. Үүнээс гадна Улаанбаатар хотын шинэ орон сууцны хорооллыг Яармаг, Буянт-Ухаа, Баянголын ам, МҮОНРТ орчимд байгуулах бололцоог хангах

үүднээс цахилгаан, дулаан, цэвэр бохир усны шугам тавих, цэвэрлэх байгууламжийг босгоход зориулан хөрөнгө гаргана хэмээн Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Ким Жанг Жин онцлов. Цаашдаа төслийн өөрийн үр ашгаас хамааран эргэн зээлээ төлөх боломжтой төслүүдэд олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогыг тус банкнаас барихаар шийджээ. Түүнчлэн барилгын материалын үйлдвэрлэл, цахилгаан станц, газрын тос болон уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох чиглэлтэй үйлдвэрлэлийг дэмжих зээл нэмэгдэх аж. Мөн Засгийн газрын “зам зуурын” гэнэтийн тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” компанид таван жилийн хугацаатай 7.35 хувийн хүүтэйгээр 100 сая ам.долларын зээл саяхан олгожээ. Өөрөөр хэлбэл, тус хөрөнгөөр “Эрдэнэс Тавантолгой” компани Баруун цанхийн хөрс хуулах ажлыг эхлүүлсэн хэмээн таамаг дэвшүүлж болох хэд хэдэн үндэслэл ч бий.

Хөгжлийн банкнаас Сангийн яам, Төрийн банкт хийсэн гэрээний дагуу 50 тэрбум төгрөгийг бага, дунд орлоготой иргэдийн орон сууцны зээлийн эх үүсвэрт зориулан эхний ээлжийн 40 тэрбум төгрөгийг олгоод байгаа аж. Өмнөх Засгийн газрын үед Хөгжлийн банкнаас 200 тэрбум төгрөгийг Төрийн банкаар дамжуулан иргэдийн орон сууцны зээлд олгоно гэсэн боловч тус шийдвэр цагийн саалтад замхрав. Засаг төрөө дагаад цаг үе ч ороо бусгаа болчих шиг. “Аливаа зүйл зохистой, тэнцвэртэй байх нь чухал. Төрийн банкны хувьд төрийн эзэмшил учраас Засгийн газрын тогтоол шийдвэрт оролцох боломжтой. Гэхдээ тус банкны өөрийнх нь олгосон зээл тогтоосон хязгаараас давсан. Өөрөөр хэлбэл, нийт хөрөнгийнхөө 60 хувиас хэтэрсэн. Тиймээс хэчнээн эх үүсвэр Төрийн банкинд өгөөд цаашид зээл олгох боломжгүй” гэж Хөгжлийн банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, Монголбанкны Хяналт, шалгалтын газрын захирал Б.Лхагвасүрэн тайлбарлалаа. ►►





Монголын төр дотоодын гурван том “зээлдэгчтэй” гэж хэлж болно. “Зээлдэгч” тус бүрдээ өөр өөрийн гэсэн онцлогтой. Хөгжлийн банк нь өр тавиад ч болтугай байшин барихыг мөрөөддөг бол Төрийн банк нь зээл өгөөд л байвал ашигтай ажиллана гэж итгэдэг. Харин Төвбанк нь өр болон ашгийг тэнцүүлэхийн ухааныг мөнгөний бодлогоортохируулах гэж хүчинзүтгэдэг. Заримдаа Засгийн газартаа ил далдаар зээл олгон, хэлсэн үгнээсээ буцаж няцдаг. Ийм л гурван өөр зүгт бодлогоо хандуулсан “зээлдэгч” дотроос хамгийн залуухан нь Хөгжлийн банк. Дөнгөж өнгөрсөн оны мөн өдийд бонд гаргах эрхээ авч байсан бол өдгөө бондыг мөнгөөр бус мөнгийг үр ашигтай төсөл, хөтөлбөрөөр солилцож сууна. Ингээд зогсохгүй, олсон хөрөнгөө Төвбанкинд хав дарсан. Хав дарах болсон шалтгаан нь санхүүжилт хийх үр ашигтай төсөл, нарийн тооцоо судалгаатай техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ бэлэн болоогүй байсантай холбоотой юм.

Хөгжлийн банкны нэг жилийн Хугацаанд байгуулсан ахар амжилт нь 600 сая ам.доллар. Түүнийхээ хүүгийн төлбөрт сард 120 сая төгрөгийн хүүг төлж байна. Хүүндээ алдагдал хүлээхгүйн тулд Засгийн газраас Хөгжлийн банкинд буй сул үлдэгдэл хөрөнгийг 1-6 сар хүртэл хугацаатайгаар Төвбанк, Засгийн газрын үнэт цаас болон арилжааны банкуудад баталгаажсан хадгаламж хэлбэрээр байршуулах шийдвэр гаргасан. Тэгвэл тус шийдвэр өнгөрсөн сарын дунд үеэс хэрэгжээд эхэлжээ. Гэхдээ Засгийн газрын тооцоолж буй 18.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг энэ онд олно гэдэгтээ Хөгжлийн банкныхан итгэлгүй байна. Хэдий арилжааны дөрвөн банкинд хөрөнгөө байршуулсан боловч хүүгээс ашиг олох, олсон орлогоосоо “Эрдэнэс Тавантолгой” компанид илүүчлэх гээд гар сарвайх зүйл их. Тиймээс ч хүүгээс ашиг олох Засгийн газрын тооцоо төсөөлөл төдий зүйл болоход ойрхон байна. Учир нь энэхүү тооцооллыг өнгөрсөн тавдугаар сард хийсэн бөгөөд тухайн үед холбогдох шийдвэрүүд гарч, Хөгжлийн банк хөрөнгийн чөлөөт үлдэгдлээ банкуудад байршуулсан нөхцөлд л

дээрх хэмжээний хүүгийн орлого олох боломжтой байжээ. Харин одоогийн байдлаар төслүүдийн санхүүжилт эрчимжин өрийн бичгийн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл багассан учраас 18.1 тэрбум төгрөгийн хадгаламжийн хүүгийн орлогыг олох зорилго талаар болж магадгүй юм. “Төмөр зам, цахилгаан станцаас эхлээд яаралтай бэлэн болсон төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах шаардлагатай. Гэтэл Хөгжлийн банкаар дамжуулан босгосон 500 гаруй сая ам.доллараас нэг ч ам.долларыг үр ашигтай төсөлд зарцуулж чадаагүй байна. Дээр нь энэ мөнгөний хүүнд төлж буй хөрөнгө дэндүү хайран” хэмээн Эдийн засгийн хөгжлийн яамны дэд сайд О.Чулуунбат халаглав.

Банк тус бүртээ бонд болон хадгаламж, үнэт цаас, алт, гадаад валютаар сангийн нөөцөө бүрдүүлдэг. Тухайлбал, Хөгжлийн банк гадаад зах зээлд бонд гаргаж хөрөнгө босгодог бол Төвбанкны хувьд дотоодын зах зээлд үнэт цаас арилжаалж, түүгээрээ хөрөнгөжих нэг эх үндсээ тавьдаг. Мөн алт хамгийн том боломж боловч Төвбанкны эцсийн зорилго энэ биш ээ. Харин Төрийн банк харилцагчийн итгэл дээр дангаар оршин тогтнож, арилжааны банкны бүх үйлчилгээг төгс үзүүлэхээр эрмэлзэх болов. Харин Хөгжлийн банкны зорилго нь зөвхөн бонд гэсэн өрийн оршихын сацуу босгосон хөрөнгөө үр ашигтай төсөлд зарцуулах, хожим нь үр шимийг хүртэх нийгмийн баялгийг бүтээх юм. Тус банкнаас “Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор”-ыг бүхий л талаар дэмжин ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн. Хамгийн гол нь аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд босгох дэд бүтэц болон боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан судалгаа, ТЭЗҮ хийх шаардлагатай аж. Уг тооцоог үндэслэн Хөгжлийн банк хөрөнгө гаргана гэсэн үг. Харин төмөр замын төсөлд Хөгжлийн банкны оролцоо ямар байх тухай Засгийн газрын шийдвэр гарсан тохиолдолд оролцох эсэхээ шийдэх аж. Эцэст нь хэлэхэд “Хөгжлийн банкны засаглал сул байна” гэж Дэлхийн банкны судлаач Н.Мөнхнасан дүгнэсэн юм. Тэрбээр засаглалд хуулиас хүчтэй улс төрийн эрх мэдэл давамгайлж байгааг онцолсон билээ. ■

РЕЙТИНГ

Г.ЦЭВЭГЖАВ: Манайх “Тогтвортой”-гоос ч илүү үнэлгээ авах боломжтой

ХасБанкны Санхүү эрхэлсэн захирал Г.Цэвэгжавтай банкны үнэлгээ болон эдийн засгийн өнөөгийн байдлын талаар ярилцлаа.

-Та АНУ-д ажиллаж байгаад Монголдоо ирээд Тэнгэр санхүүгийн нэгдэл, дараа нь ХасБанкинд ажиллаж байна. Яагаад ХасБанкыг сонгох болов?

-Би нэг жилийн өмнө Монголд ирсэн. Тэнгэр санхүүгийн нэгдэлд есөн сар Санхүү эрхэлсэн захирлын алба хашиж байгаад дөрвөн сарын өмнөөс ХасБанкны Санхүү эрхэлсэн захирлын албан тушаалд томилогдсон. Монголд ирээд ажил хайж хоёр л газар ярилцлагад орсон юм. Олон газар ярилцлагад орохыг хүсээгүй. Тэнгэр санхүүгийн нэгдэл болоод ХасБанкны өдөр тутмын үйл ажиллагаа болон эрхэм зорилгын хүрээнд баримталдаг “Эх дэлхий, эрдэнэт хүмүүн, эрүүл ашиг”-ийг эрхэмлэсэн гурван тулгуурт зарчим хамгийн их таалагдсан. Эх дэлхийгээ эрхэмлэх хүрээнд байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг харилцагч болон түншүүдээ дэмждэг. Эрдэнэт хүмүүнээ дээдлэх гэдэг зарчим нь харилцагч болон ажиллагсдын сайн сайхны төлөө үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Ашиг нь бидний нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаанаас бий болсон үнэ цэнэ юм. Энэ гурван тулгуурын дараалал нь хүртэл их утга учиртай юм.

-АНУ-д хаана, ямар ажил эрхэлж байсан бэ?

-Магистрын зэрэг хамгаалж байхдаа Денвер хотод “Вагнер тоног төхөөрөмж” компанид ажиллаж байсан. Монголд үйл ажиллагаа явуулдаг “Вагнер Ази тоног төхөөрөмж”-ийн толгой компани. Тэнд дөрвөн жил ажиллах хугацаандаа хөрөнгө зохицуулалтын шинжээч, олон улсын нягтлан бодогч хийж байлаа. Уг компанид эх үүсвэр, бэлэн болон ▶



▶ бэлэн бус мөнгөний удирдлага төсөв, санхүүгийн төлөвлөлт гэх мэт чиг үүрэгтэй ажиллаж байсан. Дараа нь Сан Франциско руу нүүж “Ресторэшин Хардвер” компанид гурван жил гаруй хөрөнгө зохицуулалтын менежерээр ажилласан. Компанийн санхүүжилт, зээл төлбөр, орж ирсэн мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгийн зохистой байдлыг удирдан ажиллаж байсан. Мөн Сан Франциско хотод “БлюФин Асоциатс” гэдэг мэдээлэл технологийн компанид Санхүү бүртгэлийн захирлаар ажиллаж байсан.

-ХасБанк сүүлийн хэдэн жил дараалан олон улсад нэр хүндтэй санхүүгийн үнэлгээний байгууллагаас “тогтвортой” гэсэн дүн авлаа. Үнэлгээг яаж тогтоож, юуг чухалчилж үздэг вэ?

-Fitch, Moody's нь дэлхийн хамгийн том дөрвөн рейтингөгдөг компаниудын жагсаалтад ордог. Манайх Moody's компаниар 2006 оноос хойш, Fitch компаниар 2008 оноос хойш үнэлгээ хийлгэлээ. Дээрх үнэлгээний компаниудын төлөөлөл жилд нэг удаа Монголд ирж, ХасБанкны үйл ажиллагаатай танилцаж санхүүгийн болон эрсдэлийн нарийн шинжилгээ хийсний дараа олон улсын аргачлалын дагуу үнэлгээ өгдөг. Нэгдүгээрт, компаниуд үнэлгээ хийхдээ мэдээж санхүүгийн зохистой байдлыг хамгийн түрүүнд харна. Активын хэмжээ хэд вэ, хэр үр ашигтай ажиллаж байна, зээлийн багцын чанар төрөлжүүлэлт, хугацаа хэтэрсэн зээлийн бүтэц, болон эрсдэлээс хамгаалсан нөөц нь хангалттай юу гээд олон зүйлийг харна. Эдгээр нь цэвэр санхүүгийн үзүүлэлт. Хоёрдугаарт, менежментийн баг, банкны тогтолцоо болон бүтэц хэр сайн байгаа, ХасБанкны дунд хугацааны 1-3 жилийн бизнес төлөвлөгөөг хардаг. Гуравдугаарт, эрсдэлийг яаж удирдаж байгааг нь хардаг. Зөвхөн санхүүгийн эрсдэлээс гадна, үйл ажиллагаа, хүний нөөц, болон мэдээлэл технологийн эрсдэл гэж бий. Энэ бүгдийг хэрхэн удирдаж байгааг нь хардаг гэсэн үг. Дөрөвдүгээрт, компанийн засаглал, хувьцаа эзэмшигчдийн бүтцийг хардаг. Харин биднээс шууд хамаарахгүй боловч үнэлгээнд нөлөөлдөг чухал хүчин зүйлс бол яах

аргагүй Монголын макро эдийн засаг, улс төрийн тогтвортой байдал, нийт банкны секторын орчин юм. Ийм олон зүйлийг нягталж байж үнэлгээгээ өгнө. Одоогийн ХасБанкны “тогтвортой” гэдэг үнэлгээ нь манай банкны бие даасан санхүүгийн чадавхид өгсөн үнэлгээ юм. Манай банк “тогтвортой”-гоос ч илүү үнэлгээ авах боломжтой. Гэвч томоохон үнэлгээний агентлагууд аливаа нэг байгууллага улсынхаа Засгийн газраас өндөр рейтингтэй байж болохгүй гэсэн зарчим баримталдаг. Тэгэхээр Монгол Улсын рейтинг өсөхгүй бол арилжааны банкуудын үнэлгээ өсөх боломжгүй. Товчхондоо, манай банк “тогтвортой”-гоос ч өндөр үнэлгээ авах чадамжтай ч Засгийн газрын рейтингээс болоод хязгаарлагдсан хэрэг. Тийм учраас улсын эрсдэлээс шалтгаалж компанийн үнэлгээг тогтоодог нь анзаарагдаж байгаа байх.

-Манай улсын рейтингийг бууруулбал ХасБанкны үнэлгээ дагаад буурах нь ээ.

-Агентлагууд ямар нөхцөл байдал, үндэслэлд тулгуурлаж үнэлгээ өгсөн талаарх тайланг байгууллагуудад өгдөг. Уг тайланд хэрхэн рейтингээ өсгөх, мөн ямар тохиолдолд буурах тухай тайлбар бичсэн байдаг юм. ХасБанкны хамгийн сүүлд авсан тайлангийн рейтинг өсгөх хэсэгт “Монгол улсын рейтинг өссөн тохиолдолд үнэлгээ өсөх боломжтой” гэсэн ганц өгүүлбэр бичсэн байна лээ. Ямар нөхцөлд рейтинг буурч болох вэ гэсэн хэсэгт нь олон нөхцөл заасан байдаг л даа. Жишээ нь, зээлийн багц эрчимтэй муудаж, хугацаа хэтэрсэн зээл 4.5 хувиас хэтэрвэл рейтинг буурч болно. Манайх энэ оны наймдугаар сарын байдлаар 1.3 хувьтай явж байна. Тэгэхээр ХасБанкны хувьд энэ тал дээр санаа зовох зүйл байхгүй. Мөн жигнэсэн активыг татварын дараах ашигтай харьцуулсан харьцаа гэж байдаг. Тэр нь 1.4 хувиас буурвал рейтингийг бууруулна. ХасБанк энэ үзүүлэлтийг мөн л сайн хангаж байгаа. Эдийн засаг гэнэт муудах, банкны салбар эрсдэлд орох гэх мэт зүйлүүдээс шалтгаалж рейтинг буурах магадлалтай. Өнөөдрийн байдлаар бууруулахгүй гэсэн таамагтай байна.

-Ингэж олон улсын үнэлгээний байгууллагаар үнэлүүлэхийн цаад шаардлага, зорилго нь юу вэ?

-Дэлхийн томоохон үнэлгээний компаниудын шалгуур өндөр байдаг. Үнэлгээ хийлгэж байгаа нь нэг талаар бид өөрсдийгөө сорьж байна гэсэн үг. ХасБанк олон улсын санхүүгийн 30 гаруй байгууллагатай хамтарч ажилладаг. Олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэснээр тэдгээр байгууллагатай хамтарч ажиллахад хялбар болно. Олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэснээр санхүүгийн тайлан маань ил тод, үнэн зөв байгааг илтгэхээс гадна бид олон улсын жишигт хүрч ажиллаж байгааг харуулна. Манайх дэлхийн топ дөрвөн хөндлөнгийн аудитын компаниар нягтлан бодох бүртгэлийн аудитыг олон улсын стандартын дагуу жил болгон хийлгээд 10 гаруй жил болж байна. Аудит маш нарийн бөгөөд жилийн тайланд аудит хийхэд дунджаар 3-4 сарын хугацаа зарцуулдаг. Ийм болохоор “Moody's” ч рейтинг өгөхдөө итгэлтэй байдаг болов уу. Буруу рейтинг өгчихвөл тэдний нэр хүнд ч сэвтэх аюултай.

-Хямрал болох нь гэж ярьж эхэллээ. Манай улсын эдийн засагчид, шинжээчид өөрсдийн таамаглалыг дэвшүүлээд, гарц хайгаад эхэлчихэж. Санхүүч хүний хувьд дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлыг аль өнцгөөс харж байна вэ?

-Таны хэлдгээр хямрал болох нь гээд бараг өдөр тутам сонин хэвлэл, зурагтаар ярьж байна. Сая Хонконг, Сингапур, Лондонд хүмүүстэй уулзахад Монголын эдийн засагт санаа зовоод эхэлсэн нь мэдрэгдлээ. Дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдлаас болж Хятадын эдийн засгийн өсөлт удааширч байгаа нь санааг нь зовоосон хэрэг. Монгол улс Хятадад их хэмжээний эрдэс, түүхийг эд экспортолдог. Тиймээс Монголын эдийн засаг Хятадын эрэлт хэрэгцээнээс шалтгаалаад удааширах магадлалтай гэсэн айдас хөрөнгө оруулагч нарт байна. Хямралаас гадна, шинэ Засгийн газар, Монголбанк ямар бодлого баримтлах эсэхийг гадаадын хөрөнгө оруулагчид ажиглаад хүлээж сууна. Манай банк урьдчилан сэргийлэх ▶

▶ арга хэмжээнүүд авч эхлээд нэлээд хэдэн сар болж байгаа. Хямралын үед эрсдэл, үйл ажилгаагаа оновчтой удирдан авч явах нь нэн чухал юм.

-Гадаадын хөрөнгө оруулагчид гарч явлаа, эдийн засаг хямарлаа гэхэд санхүүгийн зах зээлд ямар сөрөг нөлөө үзүүлэх вэ?

-Банкууд гадаадын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчдаас харьцангуй хямд эх үүсвэр татах боломжтой байдаг. Мэргэжлийн санхүүгийн хөрөнгө оруулагчид банкуудад зээл олгоход хамгийн түрүүнд эрсдэлийг хардаг юм. Банкны эрсдэлээ хэр сайн удирдаж байна, санхүүгийн үзүүлэлтүүд ямар байна гэдэгт тулгуурлана. Банкны чадавх, үйл ажиллагаа сайн байгаа хэдий ч улсынх нь макро эдийн засаг муу байвал хөрөнгө оруулагчид эрсдэлтэй гэж үздэг. Сүүлийн үед дэлхийн эдийн засаг Монголын эдийн засагт хүчтэй нөлөөлдөг болсон. Дэлхийн эдийн засгийн нөлөөгөөр манай макро эдийн засаг муудвал гадаадын санхүүгийн байгууллагууд Монголын банкуудад эх үүсвэр өгөхгүй байх, эсвэл маш өндөр хүү санал болгох сөрөг талтай. Банкууд гадаадаас өндөр хүүтэй эх үүсвэр татах юм бол Монголын том, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон иргэдэд зээлийн хүүний дарамт нэмэгдэнэ. Тэгээд цааш нь эдийн засгийн бүх циклд нөлөөлнө.

-Танайх сүүлийн 10 жилийн хугацаанд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээ хамгийн сайн хангаж ажилласан банкинд тооцогддог. Энд ямар үзүүлэлт чухал вэ?

-Монголбанк олон улсын жишгийн дагуу чанга хатуу санхүүгийн зохистой харьцааг баримталж ажиллахыг шаарддаг. Бид сар болгон Монголбанкинд тайлан тушааж байна. Ерөнхийдөө гурван том шалгуур үзүүлэлтийг хардаг л даа. Нэг нь өөрийн хөрөнгө, эрсдэлээс жигнэсэн активын харилцаа юм. Манай банкны энэ үзүүлэлт наймдугаар сарын сүүлчийн байдлаар 19.1 хувьтай явж байна. Банкны салбарын дундаж 15.2 хувь байгаа. Манайх өөрийн хөрөнгө маш сайтай, сайн капиталжуулсан банкинд тооцогддог. Мөн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн

харьцаа нь ч гэсэн Монголбанкны тогтоосон хэмжээнээс хавьгүй илүү. Наймдугаар сарын байдлаар 13.8 хувьтай байна. Гэтэл банкны салбарын дундаж нь 11.4 хувьтай байх жишээтэй. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар гэж чухал үзүүлэлт бий. Монголбанк дор хаяж 25 хувийн төлбөр түргэн гүйцэтгэх хөрөнгө байлгахыг шаарддаг. Энэ шаардлагыг манай банк давуулан биелүүлж 38.2 хувьд барьж байгаа. Дэлхийн хэмжээнд арилжааны банкуудад тавигддаг шалгуур үзүүлэлтүүдийг манай банк олон жил сайн хангаж ажиллаж байна.

-Үүнийг эдийн засаг хямарлаа гэхэд ХасБанк харилцагчдаа ямар нэг эрсдэлд оруулахгүй хамгаалалт гэж ойлгож болох уу?

-Манай банк Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон гүйцэтгэх удирдлагын төвшинд ажилладаг

нэлээд хэдэн хороотой. Компанийн сайн засаглалыг бүрдүүлж ажиллах хүрээнд олон хороо байгуулсан. Банкны эрсдэлийн хороо сардаа доод тал нь хоёр удаа хуралдаж, олон улсын эдийн засаг, Монголын макро эдийн засаг, банкны салбарын нөхцөл байдал хэр байгааг хэлэлцдэг. Банкны зүгээс эдгээр хороодыг байгуулан ажиллаж байгаа нь ХасБанк учирч болох эрсдэлийг тооцоолсон санхүүгийн маш нарийн удирдлагатай ажилладагийн илэрхийлэл мөн. Эрсдэл гарч болзошгүй тохиолдолд сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь яаралтай авч эхэлдэг. Энэ бүгд нь бидний үнэ цэнэтэй харилцагчдынхаа төлөө хийж байгаа чухал арга хэмжээнүүд юм. ХасБанк хямралаас сайн хамгаалагдсан гэдэгт итгэлтэй байдаг.

Ярилцлага өгсөнтандбаярлалаа. Таны ажилд амжилт хүсье. ■

ЭРСДЭЛИЙГ УДИРДАХУЙ

ДААТГАЛ ТОЙРСОН АСУУДАЛ

Э.ЗОРИГТ

...Манайх шиг албан журмын даатгалын ойлголт буруу, сайн дурын даатгалын талаарх мэдлэг тааруу, салбарын хөгжил сул зах зээлд даатгуул хэмээн дээрээс “зарлигдах” нь тийм ч зөв арга биш...

Жихүүн салхитай бүүдгэр өдөр. Гандангийн тагтаа будаа тоншиж, эрх эргүүлсэн лам, хүрд эргүүлсэн хүмүүс өөрийн болоод өрөөлийн зовлонг бурхан гэгч биегүй орон зайд даатгаж, сэтгэлдээ

залбирна. Гэнэтийн золгүй явдлаас учирсан гай зовлонг гэтлэх хийгээд болзошгүй гачлангаас сэргийлэхийн тулд монголчууд хийд хэмээгч бурхадын “гэрт” зочилдог. Харин дэлхийн нөгөө өнцөгт эрсдэл буюу ▶



Эрэлт, нийлүүлэлт хамт оршин байж зах зээл үүсдэг жамтай. Тэгвэл манай даатгалын салбарын хөгжилд чөдөр болж байгаа зүйл бол эрэлтийн талын буюу иргэдийн дунд тархсан буруу ойлголт аж. Уг нь даатгалын салбарын хөгжил иргэдийн сайн дурын хүсэл сонирхол

▶ хохирол учруулж болзошгүй үйл явдлаас урьдчилан сэргийлэхээр даатгал гэх санхүүгийн арга хэрэгслээр өөрийгөө “хамгаалдаг” байна. Даатгалд хамрагдсанаар та эрсдэлийг шилжүүлэх, бууруулах, зугатах, хүлээх аргаар удирдаж болдог аж.


Ойролцоогоор зургаан зууны тэртээ далайчдын дунд үүссэн даатгалын систем нь анхнаасаа л эрсдэлийг үнэлж, өөртөө шилжүүлэн авдаг санхүүгийн үйлчилгээ үзүүлэх шилдэг арга байжээ. Тиймээс ч эдийн засаг хөгжих тусам даатгалын хэрэгцээ ихэсдэг бөгөөд өндөр хөгжилтэй гаднын орнуудад даатгал нь тухайн улсын эдийн засгийн тулах баганын нэг болж байдаг аж. Харин манай улсын хувьд даатгалын түүх 70 жилийн өмнөөс эхтэй бөгөөд энэ талын хууль анх 1997 онд батлагдаж, 2004 онд шинэчлэгдсэн байна. Хэдэн зуун дамжин хөгжиж ирсэн даатгалын салбар манай улсад хожуу “мэндэлсэн” нь харамсалтай. Тэр бүү хэл, 70 жилийн түүхийг ардаа орхисон манай даатгалын салбар иргэдийн тархинд буруу ойлголт үлдээсэн гэдгийг холбогдох хүмүүс хэлдэг. Түүнчлэн даатгалын салбарт нэн тэргүүнд сайжруулах хэд хэдэн асуудал байгаа аж.

Асуудал: /Даатгал татвар биш/

Нийлүүлэгч тал олон байгаа үед үйлчлүүлэгчид хождог нь зах зээлийн энгийн дүрэм. Тиймээс энэ нь салбарын зах зээл эрүүлжих нэг хэлбэр. Хэдийгээр зах зээлд

дээр тогтдог гэдэг. Гэтэл манайд эсэргээрээ. Үүний шалтгааныг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга С.Ганболд “Манайд даатгалын салбар анх үүссэн цагаасаа л нийгмийн, эрүүл мэндийн гээд албан журмын даатгалаар ард иргэдээ бөмбөгдөж, баахан мөнгө татчихаад нөхөн олговор олгохдоо хойрго ханддаг байсан нь иргэдийг даатгалын талаар буруу ойлгоход хүргэсэн. Тиймээс иргэд даатгалыг татвар мэтээр буруу ойлгодог” гэсэн юм. Гэхдээ сүүлийн жилүүдэд даатгалын салбарын нөхөн төлөлтийн хэмжээ харьцангуй өссөн нь доорх (график 2)-оос харагдана.

Хэдийгээр нөхөн төлөлтийн хэмжээ жил ирэх бүр өсөж байгаа ч иргэдийн дунд сайн дурын даатгалын талаарх мэдлэг тааруу хэвээр. Тухайлбал, Хан-Уул дүүргийн иргэн Б.Золбоо “Үнэнийг хэлэхэд даатгалын талаар тийм ч сайн мэдлэг байхгүй. Ер нь бол даатгалыг ХАОАТ, НДШ, Жолоочийн хариуцлагын гэх мэт төрөөс албан журмаар хамруулдаг даатгалаар л ойлгож байгаа” гэсэн юм. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал угаасаа даатгалын талаар ойлголт, мэдлэг тааруу иргэдийг бүр төөрөгдүүлж орхив. Жолооч нарын дунд “Жолоочийн ▶




нийлүүлэгч талын өрсөлдөөн сайжирч байгаа боловч эрэлтийн талд асуудал байгааг холбогдох хүмүүс хэлж байсан юм.

► хариуцлагын даатгал чинь тэгээд жолоочоо даатгаад байгаа юм уу, машинаа даатгаад байгаа юм уу”, “Энэ бол Хүний хөгжлийн 21 мянган төгрөгөө буцааж авах төрийн муу санаа”, “Даатгалын компаниуд төрийн томчуудад авлига өгч хийлгэж байгаа ард иргэдээ мөлжих гэсэн явуулга” гэх мэт хардаж сэрдсэн, эргэлзэж тээнэглэсэн яриа хаа сайгүй гарч байна. “Мандал Женерал” даатгалын компанийн гүйцэтгэх захирал М.Давааням “Даатгалын салбарт амжилттай үйл ажиллагаа явуулахын тулд эхлээд ард түмэнд даатгалын боловсрол олгох ёстой. Тэгж байж л сайн дурын даатгал хөгжинө. Гэтэл манайхан өмнө нь ч, одоо ч гэсэн даатгал гэдэг юу вэ гэдгээ иргэдэд ойлгуулаагүй байж даатгуул гээд албадаад байдаг. Жолоочийн хариуцлагын даатгал хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Ямар учраас хэрэгтэй гэдгийг нь ойлгуулах ёстой” гэсэн юм. Дээрээс нь манай жолооч нар хэнд, яах гэж тодорхой хэмжээний хураамж төлж байгаа гэдгээ сайтар нягталж шалгадаггүй гэдгийг холбогдох хүмүүс анхааруулсан юм. Хуульд зааснаар, “Жолооч нь замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулж болзошгүй

хохирлыг нөхөн төлөх зорилгоор Жолоочийн даатгалын тухай хуульд заасан нөхцлийн дагуу даатгагчтай даатгалын гэрээ байгуулна” гэжээ. Энэ талаар Давааням “Уг даатгал хөндлөнгийн этгээд буюу зорчигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хийж байгаа. Тодруулбал, жолооч нь бусдын амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгийн төлөө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх зорилготой юм” гэв.

Гаднын хөгжингүй орнуудад албан журмын даатгалаар даатгалын салбарын хөгжлийг дэмжих, нийгэмд эмх цэгц тогтоох үүднээс төрөөс нэгдсэн журмаар явуулдаг санхүүгийн шилдэг арга байдаг. Гэхдээ манайх шиг албан журмын даатгалын ойлголт буруу, сайн дурын даатгалын талаарх мэдлэг тааруу, салбарын хөгжил сул зах зээлд даатгуул хэмээн дээрээс “зарлигдах” нь тийм ч зөв арга биш. Харин эхнээс нь иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх буюу “Даатгал гэдэг нь танд болоод таны ойр дотнынхонд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг хамгаалах хөрөнгийн хуримтлал” гэдгийг ойлгуулах тал дээр хаа хаанаа анхаарах ёстойг салбарын хүмүүс хэлж байна.

Асуудал: /Хуулийн садаа/



Манай даатгалын салбар хөгжихгүй байгаа өөр нэг шалтгаан бол компаниудын нийт эргэлтийн хөрөнгө байдаг аж. Эргэлтийн хөрөнгө багатай учраас томоохон компаниуд дотоодын даатгалын компанид итгэдэггүй байна. Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө энэ оны хоёрдугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс 1.35 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой аж. Хэдийгээр салбарын үзүүлэлт өсөлттэй явж байгаа ч энэ нь тийм ч хангалттай дүн биш гэнэ. Ганболд “Манай даатгалын компаниуд хөрөнгийн хувьд ч үйл ажиллагааны хувьд ч жижигхэн байна. Өнөөдөр даатгалын компаниудын үндсэн хөрөнгө хэдхэн тэрбум төгрөгийн дотор эргэлдэж байна. Харин уул уурхайн компаниудын эрсдэл хэдэн тэрбум ам.доллараар үнэлэгдэнэ” гэв. Тиймээс манай даатгалын компаниудын үндсэн хөрөнгийн хэмжээг томоохон уул уурхайн компаниуд “голдог” гэнэ. Уг нь хуульд зааснаар Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ямар ч компани СЗХ-нд бүртгэлтэй даатгалын компанид зайлшгүй даатгуулсан байх шаардлагатай талаар заалт байдаг ажээ. Гэтэл ихэнх уул уурхайн компани, тэр дундаа гаднын хөрөнгө оруулалттай компани даатгуулдаггүй ►

Хүснэгт-1.

Даатгалын хэлбэр	2011.06.30	2012.06.30	Өөрчлөлт
	Даатгалын нийт нөхөн төлбөр(сая.төг)		
1.2. Хөрөнгийн даатгал	580.4	502.0	-78.4
1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал	2 061.3	048.9	987.6
1.8. Агаарын хөлгийн даатгал	5.5	8.7	3.2
1.10. Хариуцлагын даатгал	185.2	118.2	-67.00
1.1. Гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал	560.6	853.3	292.70
1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	449.7	1 195.8	746.10
1.11. Санхүүгийн даатгал	350.6	618.2	267.60
1.5. Барилга угсралтын даатгал	1.3		-1.30
1.4. Ачааны даатгал	58.7	90.7	32.00
2.1. Хугацаат амьдралын даатгал	11.9	23.8	11.9
2.5. Эрүүл мэндийн даатгал	30.0	36.0	6.0
1.7. Мал амьтдын даатгал	5.8	0.0	-5.80
1.6. Газар тариалангийн даатгал		0.0	0.00
2.3. Хуримтлалын даатгал	6.4	32.0	25.6
2.4. Тэтгэврийн даатгал		3.5	3.5
ДҮН	4 307.4	6531.1	2182.70

► байна. СЗХ-ныхон “Бид уул уурхайн компани дээр очоод шаардлага тавихаар ихэнх нь том дарга гадаадад байгаа гээд халгаадаггүй. Мөн томоохон уул уурхайн компаниуд нь манай даатгалын компаниудын нөөц санг голоод гадаадад даатгуулчихдаг. Манайхаас даатгуул гэж шаардах л эрхтэй болохоос үйл ажиллагааг нь зогсоох эрх мэдэл байхгүй. Тиймээс төрөөс хуулийн хэрэгжилтэд анхаарах хэрэгтэй. Хэдийгаар манай хороо хууль хэрэгжүүлэх үүрэгтэй ч бидний хүн хүч, эрх мэдэл үнэхээр хүрэлцэхгүй байна” гэсэн юм. Эндээс харахад манай даатгалын компаниудын хөгжил, тэднийг дэмжсэн хуулийн хэрэгжилт ямар түвшинд байгаа нь тодорхой харагдана.

Даатгалд хатуурхахын хэрэг байна уу

Энэ оны хоёрдугаар улиралд даатгалын компаниуд учирч магадгүй их хэмжээний эрсдэлээ гадаадын давхар даатгалын компаниудад даатгуулж, 11.2 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 5.9 тэрбум төгрөгөөр буюу 2.09 дахин өссөн дүнтэй гарсан байна.


Давааням “Манай даатгалын компаниуд хөгжлийнхөө гараан дээр яваа нь үнэн. Гэхдээ салбарын хөгжилд хуулийн зарим заалт саад болж байна. Тухайлбал, даатгалын компани хөрөнгийн зах зээл дээр тоглолт хийхийг хориглодог. Тэгсэн мөртлөө дотоодын компаниудаа дэмжихээр гаргасан хууль дүрмээ сахиулах тал дээр учир дутагдалтай ханддаг” гэсэн юм. Дэлхийн улс орнуудын жишгээс харахад даатгалын компаниуд ихэвчлэн ХК буюу олон нийтэд нээлттэй хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байна. Өөрөөр хэлбэл даатгалын компаниуд нь хөрөнгийн зах зээл дээр мөнгө босгож, хөрөнгө, санхүүгийн чадавхиа сайжруулах боломжтой байдаг аж. Харин манай улсад мөрдөгдөж буй даатгалын тухай хуулиар хөрөнгийн зах зээлд орох нь хориотой байгаа. Харин



даатгалын компани нь хөрөнгийнхөө тодорхой хувийг үл хөдлөх хөрөнгөд оруулах мөн арилжааны банкинд хадгалуулахыг зөвшөөрдөг гэнэ. Энэхүү хуулийн заалтад өөрчлөлт оруулж, даатгалын компаниудыг хөрөнгийн зах зээлд орох боломжийг нээх асуудал өнгөрсөн оноос яригдсан ч өнөөг хүртэл сураг чимээгүй.

Төгсгөлийн оронд

Уг нь даатгалын салбар аливаа улс орны санхүүгийн хамгийн хүчирхэг зэвсэг байдаг гэдэг. Гэтэл манайд иргэд нь итгэдэггүй, төр нь дэмждэггүй, өөрсдөө ч зүтгэдэггүй “залхуу” салбар гэхэд хэлсдэхгүй. Тиймээс энэ салбарын хөгжлийг хаа хаанаа дэмжих хэрэгтэй гэдгийг мэргэжилтнүүд хэлж байсан. Нийгэм, эдийн засгийн чадавх сайжирч байгаа өнөө үед хувийн хэвшлийнхэн овсгоотой байж даатгалын шинэ бүтээгдэхүүн гаргах замаар иргэдийн буруу ойлголтыг засах, шинээр эрэлт үүсгэх боломж байгаа аж. Түүнчлэн төр, засгийн бодлого тодорхойлогчид даатгалын зах зээлийн нөөц боломжийг зөв үнэлж, бодлогоор дэмжих хэрэгтэй. Ингэж чадвал манай даатгалын салбар ойрын хэдэн жилийн дотор дотооддоо төдийгүй гадагшаа өрсөлдөх боломжтой гэдгийг салбарынхан дуу нэгтэй хүлээн зөвшөөрч байсан юм. ■





ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ “ХӨГЖИЖ БУЙ” ЗЭРЭГЛЭЛД БАГТААНА

Энэ оны нэрлэсэн үнээр ДНБ (үйлдвэрлэлийн аргаар) 2012 оны эхний гурван улиралд өмнөх оны мөн үеийнхээс 23.5 хувиар өсч, 9922.2 тэрбум төгрөгт хүрлээ. ДНБ 2005 оны зэрэгцүүлэх үнээр өмнөх оны мөн үеийнхээс 12,7 хувиар өсч, 3864.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2012 оны есдүгээр сард өмнөх сараас

нэг хувь, оны эхнээс 13,4 хувь, өмнөх оны мөн үеээс 14.8 хувиар өслөө. Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар болон сургалтын төлбөрийн үнэ дүнгээрээ 39.9 хувиар өссөнөөр голлох нөлөө үзүүлсэн ажээ

Монголын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд. Өмнөх оны мөн үетэй харьцуулсанаар /хувиар/

ДНБ		Үйлдвэрлэл		Хэрэглэгчийн индекс	Ажилгүйдлийн үзүүлэлт, %	Төлбөрийн тэнцэл		Төсвийн тэнцэл ДНБ-т эзлэх хувиар 2012	Зээлийн хүү	Валютын ханш	
Хамгийн сүүлд	2012	Хамгийн сүүлд	Хамгийн сүүлд			Хамгийн сүүлд	Хамгийн сүүлд				12.10.22
12,70%	15-17%	7,20%	13,40%		7.70%	(-2248.8) сая \$		(-532.5)%	13,25	1384,77	1291,71


Мөнгөний зах зээл /хувиар/

UBIBOR	12.10.01	12.10.22
Нэг өдрийн	13,2500	13,2429
Нэг долоо хоногийн үзүүлэлт	13,5643	13,6500
Нэг сарын үзүүлэлт	14,5429	14,5929
Гурван сарын үзүүлэлт	15,3571	15,4000
Зургаан сарын үзүүлэлт	15,9786	15,9929
Нэг жилийн үзүүлэлт	17,0500	17,3286

Мөнгөний зах зээл /хувиар/

LIBOR	Энэ долоо хоног	Сарын өмнөх	Жилийн өмнөх
Нэг сарын үзүүлэлт	0,21	0,22	0,25
Гурван сарын үзүүлэлт	0,33	0,38	0,41
Зургаан сарын үзүүлэлт	0,59	0,66	0,60
Нэг жилийн үзүүлэлт	0,94	1,00	0,91

Хөрөнгийн зах зээл



“Монголын Хөрөнгийн бирж”, ТӨХК, Төрийн өмчийн хороо болон Лондонгийн хөрөнгийн биржийн хооронд байгуулсан стратегийн хамтын ажиллагааны “Ажлын мастер гэрээ” –ний хүрээнд хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажлуудыг тодорхой үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж байна.

Таваарын үнэ ханш

Таваар	Хэмжүүр	Төгрөг	ам.доллар
			12.10.22
Алт	Трой Унци	2,389,309.85	1,725.42
Мөнгө	Трой Унци	44,644.98	32.24
Зэс	Паунд	5,067.15	3.66
Уран	Паунд	60,237.50	43.50
Төмрийн хүдэр	Метр тонн	157,725.30	113.90
Молибдениум	Паунд	15,703.29	11.34

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК энэ оны долдугаар сарын 2-нд арилжаа, төлбөр тооцоо, хянахын цогц шийдэл бүхий “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлсэн билээ. Шинэ систем болон хууль, эрх зүйн актаар тавигдаж буй шаардлагуудыг бүрэн хангасан 44 брокер, диллерийн компани өнөөдөр хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцож байгаа бөгөөд олон жилийн дунджаас харахад эдгээр брокер, диллерийн компани зах зээлийн нийт арилжааны 95 хувийг бүрдүүлж байна.

Энэ оны эхний есөн сарын байдлаар нийт 142.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 81.3 тэрбум төгрөгөөр буюу 2.3 дахин их, харин өнгөрсөн оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 33.4 тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн байна.

2012 оны эхний хагас жилийн байдлаар нийт 61 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийж, өдрийн дундаж арилцааны хэмжээ 463 сая төгрөг байсан бол өнгөрсөн долдугаар сарын 2-ноос буюу шинэ системийг ашиглалтад оруулсан өдрөөс өнөөдрийг хүртэл 81.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааны арилжаа хийгдэж, өдрийн дундаж арилжааны хэмжээ 1.4 тэрбум төгрөгт хүртлээ өссөн үзүүлэлттэй байгаа юм. ▶

Эх сурвалж: www.mse.mn

ТОП 20 индекс

12.10.22	12.09.30	өөрчлөлт
16502.7	17106.9	-3.56%

Гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголын уул уурхайн компаниудын хувьцаа

	Бирж	Валют	12.10.22
Оюу толгой ресурс	Торонто	CAD	7.83
Сауд гоби ресурс	Торонто	CAD	7.83
Сентерра гоулд	Торонто	CAD	11.33
Энтрий гоулд	Торонто	CAD	0,415
Петро матад	Лондон	GBP	7,75
Монголиан энерги корп	Хонконг	HKD	0,36
Монголын уул уурхайн корп	Хонконг	HKD	3,97

Санхүүгийн зах зээлийн онцлох үйл явдал

- Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын жагсаалт”-нд (FTSE Watch List) багтаасан

- Шинэ системийн дагуу тавигдаж буй шаардлагыг хангасан компанийн тоо дөрвөөр нэмэгдэж нийт 48 брокер дилерийн компани арилжаанд оролцох эрхтэй боллоо.

- Төлбөрийн баталгааны санд хөрөнгө байршуулсан компанийн тоо 56, МХБ-тэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан 68 компани, төлбөр тооцоо гүйцэтгэгч банктэй гэрээ байгуулсан 55 компани, барьцаа хөрөнгөө байршуулсан компанийн тоо 50-д тус тус хүрсэн бөгөөд дээрх шалгуурыг ханган Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцох эрх нь нээлттэй 48 брокер диллерийн компани байна.

- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2013 оны 09 сарын 13-ны өдрийг хүртэл шинээр үнэт цаас гаргаж буй компаниудын бүртгэлийн хураамжийн хэмжээг 30 хувиар,

ТОП 20-ийн хувьцаа


№	МХБ TOP 20	Төрөг		Өөрчлөлт	ам.доллар	Зах зээлийн үнэлгээ /ам.доллар/
		01.X	19.X			
1	АПУ	3800	3500	-7.89%	2.53	260,006,950,000
2	Багануур	6065	5500	-9.32%	3.97	408,582,350,000
3	Баянгол зочид буудал	38360	35000	-8.76%	25.27	2,600,069,500,000
4	BDSec	3450	3300	-4.35%	2.38	245,149,410,000
5	Говь	3840	3802	-0.99%	2.75	282,441,835,400
6	Женко тур	86	88	2.33%	0.06	6,537,317,600
7	Могойн гол	17000	15500	-8.82%	11.19	1,151,459,350,000
8	Монгол шилтгээн	1000	1000	0.00%	0.72	74,287,700,000
9	Монголиа девелопмент ресорсес	900	901	0.11%	0.65	66,933,217,700
10	Монголын цахилгаан холбоо	2000	1993	0.35%	1.44	148,055,386,100
11	Ремикон	187	186	-0.53%	0.13	13,817,512,200
12	Силикат	185	195	5.41%	0.14	14,486,101,500
13	Сүү	80000	80000	0.000%	57.77	5,943,016,000,000
14	Тавантолгой	9000	8000	-11.11%	5.78	594,301,600,000
15	Талх чихэр	12200	12000	-1.64%	8.67	891,452,400,000
16	Улаанбаатар зочид буудал	72500	75000	3.45%	54.16	5,571,577,500,000
17	Улсын их дэлгүүр	430	400	-6.98%	0.29	29,715,080,000
18	Хөх ган	185	181	-2.16%	0.13	13,446,073,700
19	Шарын гол	9000	8800	-2.22%	6.35	653,731,760,000
20	Шивээ-Овоо	10000	9000	-10.000%	6.50	668,589,300,000

харин нэмэлт үнэт цаас гаргаж буй тохиолдолд 50 хувиар хөнгөлөхөөр шийдвэрлээд байна.

- Өнгөрсөн долоо хоногийн Төрийн өмчийн хорооны хурлаар Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийн Төлөөлөн удирдах зөвлөлийн

гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ буужээ.

- Монголын хөрөнгө оруулалтын дээд хэмжээний уулзалт /Mongolian Investment Summit 2012/ энэ сарын 30-31-нд Хонконгт болох гэж байна. ■



ТАЙЛАН

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ МОНГОЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ



Л.АМАР
/АХБ-ны Суурин төлөөлөгчийн
газрын эдийн засагч/



ЯАН ХАНСЭН
/АХБ-ны Суурин төлөөлөгчийн
газрын ахлах эдийн засагч/

...Азийн хөгжлийн төлөвийн талаарх шинэчилсэн тайланд дурдсанаар /энэ оны аравдугаар сарын 4-нд гарсан/ дэлхийн эдийн засаг энэ оны эхэнд төсөөлж байснаас сайжрахгүй байна. АНУ, Евро бүс, Япон зэрэг аж үйлдвэржсэн томоохон улсын эдийн засгийн өсөлт ирэх жил эргэн сэргэх төлөвтэй боловч дэлхийн эдийн засгийг хойш чангаасаар байх шинжтэй байна...

БНХАУ, Энэтхэг улсын ДНБ тогтвортой өснө гэж үзэж байгаа боловч хоёр улсын одоогийн эдийн засгийн өсөлтийн хурд дэлхийн санхүүгийн хямралын өмнөх түвшиндээ хүрэхгүй байна. Шийдэл хүлээж буй Европын өрийн хямралаас үүдэн гарч болзошгүй бэрхшээл АНУ-ын санхүүгийн огцом хүндрэл нь дэлхийн эдийн засагт уналт дагуулсан том эрсдэлийг учруулсаар. Нэг үгээр хэлбэл, Дэлхийн эдийн засгийн удаашрал нь Монголын эдийн засгийг эмзэг болгож байна. Аж үйлдвэржсэн томоохон эдийн засгуудын төлөв байдал энэ оны эхэнд төсөөлж байснаас сайжирсангүй. Дотоодын хувийн салбарын эрэлт хүчтэй сэргэж чадаагүйн улмаас ДНБ-ий өсөлт энэ онд 1.1 хувь, ирэх онд 1.5 хувийн түвшинд байх төлөвтэй байна. БНХАУ болон Энэтхэгийн эдийн засгийн өсөлт саарч байгаа нь дэлхийн эдийн

засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх боллоо. Дэлхийн ДНБ болон импортын эрэлтийн хэмжээнд тус хоёр улсын эзлэх хувь хэмжээ улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь бүс нутаг болоод олон улсын бизнесийн мөчлөгт үзүүлэх нөлөө жинтэй болж байна.

АНУ: Төсвийн хүндрэл, ажилгүйдлийн өндөр түвшин

АНУ-ын эдийн засгийн байдал Евро бүсээс харьцангуй сайн байгаа боловч тус улсын эдийн засгийн өсөлт харьцангуй удаан буюу энэ онд 1.9 хувь, ирэх онд 2.1 хувь байх төлөвтэй байна. Тус улсын гадаад хүчин зүйлсийн тодорхой бус байдлаас илүүтэйгээр дотоодын төсвийн бодлогын нөхцөл, чиг хандлага,

ажилгүйдлийн өндөр түвшин нь АНУ-ын эдийн засагт ихээхэн хүндрэл учруулж байна. Тус улсын эдийн засгийг цаашид удаашрахаас сэргийлж, уналтад ороод буй хөдөлмөрийн зах зээлийг сэргээх зорилгоор Холбооны нөөцийн банк мөнгөний нийлүүлэлт нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ дахин авч хэрэгжүүлэхээ өнгөрсөн есдүгээр сарын эхэнд мэдэгдсэн. Тиймээс АНУ-ын эдийн засагт тулгарч буй хамгийн том эрсдэл нь төсвийн хүндрэл юм. 2008-2009 оны санхүүгийн хямралын дараа тус улсын бодлого боловсруулагчид уналтаас үүсэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор олон тооны сангийн хөтөлбөр, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тэдгээрийн нэлээд хэсэг нь хэдэн жилээр үргэлжилсэн бөгөөд АНУ-ын ДНБ-ий ойролцоогоор дөрвөн хувьтай тэнцэх хэмжээний төсөв шаардсан эдийн засгийг дэмжих арга хэмжээ ирэх оны эхээр ▶▶



▸ дуусахаар төлөвлөсөн байна. АНУ-ын бодлого боловсруулагчид татварыг бууруулах богино хугацааны арга хэмжээнүүдийнхээ заримыг ирэх онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцоонд хүрч магадгүй байгаа. Гэвч ДНБ-ий 1.7 хувьтай тэнцэх хэмжээгээр төсвийг бууруулах нэг бараг гарцаагүй болоод байна. Төсвийн түр арга хэмжээнүүдийг цааш үргэлжлүүлэхгүй бол ирэх онд АНУ-ын эдийн засаг дахин уналтад орж болзошгүй.

Европын өрийн хямрал дэлхийн эдийн засгийг хойш татсан хэвээр

Евро бүсийн хямрал нь тус валютын холбооны эдийн засагт ихээхэн хүндрэл учруулсаар байна. Төсвийн танах бодлого баримталж, төрийн болон хувийн салбарын зээлдэгчдэд олгох зээлийн хүүг нэмсэн нь өмнөд Европ тухайлбал, Итали, Испанид хямралыг гүнзгийрүүлж байна. Германы эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр байсны үр дүнд оны эхний хагаст Евро бүсийн эдийн засгийн бууралт бүхэлдээ бага түвшинд гарсан. Харин жилийн сүүлийн хагаст эдийн засгийн өсөлт үлэмж хэмжээгээр саарч, ДНБ жилд 0.6 хувиар буурах төлөвтэй

байна. 2013 онд ДНБ-ий хэмжээ 0.5 хувиар өсөж ялимгүй сэргэх хандлага ажиглагдах болов. Европын холбооны болон дэлхийн хэд хэдэн дээд хэмжээний чуулга, уулзалт дээр Европын тогтвортой байдлыг хангах механизмын дүрмийг өөрчлөх, банкны нэгдсэн холбоо байгуулах зэрэг евро бүсийн өрийн хямралыг шийдвэрлэх зорилготой хэд хэдэн арга хэмжээг дэмжсэн байна. Гэвч үүний хүрээнд тус валютын холбооны бүтцийн асуудлыг шийдвэрлэх тодорхой төлөвлөгөөг батлаагүй юм. Хямралд өртөөд буй орнуудын зээлийн хүүгийн түвшинг хянаж болохуйц хэмжээнд барих зорилгоор Европын төв банкаас (ЕТБ) Засгийн газрын өрийн зах зээлд шууд интервенц хийхээр шийдсэн нь түр хугацаанд хүндрэлийг зөөлрүүлсэн явдал боллоо. Өмнөд Европын өрийн хэмжээ ихтэй орнууд нь урт хугацаанд өсөлтийг бий болгоход чиглэсэн шинэтгэлийг зах зээлдээ хийж чадахгүй бол санхүүгийн зах зээл дээрх оролцогчид өөр орнуудад хөрөнгө оруулалтыг шилжүүлэх эсвэл өндөр хүүгийн төлбөрийг шаардаж болзошгүй байна.

Японы эдийн засгийн өсөлт удааширна


2011 оны гуравдугаар сард болсон газар хөдлөлтөөс хойш

төсвийн зардал, сэргээн босголтын үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор Японы эдийн засгийн сэргэлт энэ онд эрчээ авч байна. Японы эдийн засгийн өсөлт энэ онд 2.3 хувиар өсөж, 2013 онд 1.6 хувь болж буурах хандлагатай байгаа юм. Тус улсад өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өнгөрсөн долдугаар сард ялимгүй буурч, дахин дефляци үүсэв. Дэлхийн санхүүгийн хямрал эхэлсэнээс хойш хэрэглээний барааны үнэ сар бүр буурсаар байгаа боловч 2011 оны дунд үетэй харьцуулахад үнийн уналтын хурд саарчээ. Иймд Японы төвбанк эдийн засгийн нөхцөлд таарсан бодлогоо үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэх болно.

БНХАУ-ын эдийн засаг саарч байна

Хятадын эдийн засгийн өсөлт буурч байгаа хэдий ч цаашид мөнгөний нийлүүлэлт, төсвийн бодлого тэлэх орон зай байна. Гадаад эрэлт буурч, эдийн засгийн өсөлтөд гол нөлөө үзүүлэгч дотоод хүчин зүйлийн хурд саарсаны улмаас БНХАУ-ын ДНБ-ий өсөлт төсөөлж байснаас удааширч энэ оны эхний хагаст өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувь болж буурав. Өмнөх оны мөн үед энэ үзүүлэлт 9.6

хувьтай байсан юм. Дотоодын эрэлт хэрэгцээ буурсаны гол шалтгаан нь үл хөдлөх хөрөнгийн салбарт хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, дэд бүтцийн хөгжлийн хурд саарсан явдал байлаа. Эдийн засгийн тодорхойгүй байдал нэмэгдсэний улмаас өмнөх жилтэй харьцуулахад хэрэглээний өсөлт удааширчээ. Жилийн эхний найман сард экспортын өсөлт 7.1 хувь болж буурч, импортын өсөлт 5.1 хувь болж багасан өмнөх оны эхний найман сартай харьцуулахад 2.7 хувиар бага байна. Түүхий эдийн үнэ унаж, газрын тос, ган, зэс, нүүрс зэрэг түүхий эд, завсрын бүтээгдэхүүний импорт багассан нь нийт импортыг огцом буурахад хүргэсэн байна. Учир нь нийт импортын тал хувь нь дахин боловсруулаад экспортод гаргадаг завсрын бүтээгдэхүүнээс бүрддэг. Засгийн газар есдүгээр сард эдийн засгийг дэмжих нэмэлт арга хэмжээ авахаа зарлаж, томоохон хот суурин, зангилаа газруудад нийт 800 тэрбум юанийн хөрөнгө оруулалттай төмөр замын 13 төсөл хэрэгжүүлж, энэ чиглэлийн 12 төслийн судалгаа хийхээр болов. Үүнээс гадна орон нутгийн зарим засаг захиргаа дэд бүтэцтэй холбоотой томоохон төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхээ зарлаад байна. Хятадын инфляци буурсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд сулруулах боломжийг бүрдүүлж байна. Мөнгөний бодлогыг байсныг Түүнчлэн Хятадын эдийн засгийн өсөлт 2011 онд 9.3 хувиас 2012 онд 7.7 хувь хүртэл буурч, 2013 онд 8.1 хувь болж эргээд өсөх төлөвтэй байна. Эдийн засгийн мөчлөг сөрсөн сангийн бодлогыг үргэлжлүүлж, дэлхийн эдийн засгийн байдал сайжирсанаар 2013 онд тус улсын эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ гэж үзэж байна. Үл хөдлөх хөрөнгөд хийх хөрөнгө оруулалтын өсөлт 20 орчим хувьтай байхаар тооцоолсон бөгөөд энэ нь цаашид өсөлтийн томоохон хөдөлгөгч хүч хэвээр байх юм. Үүний хүрээнд Засгийн газар дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулж өсөлтийг дэмжих болно. Төсвийн тааламжтай байдал үргэлжилж, инфляци буурч байгаа нь цаашид шаардлагатай тохиолдолд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломжтойг харуулж байгаа юм. Энэ нь эдийн засаг огцом ▶



► буурахаас сэргийлэх боломж олгож байна.

Дэлхийн эдийн засаг улам удаашрах эрсдэл байна

Шийдвэрлэж чадахгүй байгаа еврогийн хямрал, АНУ-ын төсвийн хүндрэл нь дэлхийн эдийн засагт ихээхэн эрсдэлтэй юм. Өрийн хямралаас үүдэлтэй хүндрэлүүд Евро бүсэд уналтыг улам гүнзгийрүүлж болзошгүй байна. АНУ төсвийн хөтөлбөрүүдээ хэрэгжүүлэх хугацааг 2013 онд сунгаж чадахгүй бол цаашид хувийн салбарын эрэлт буурч, ирэх онд АНУ-ын эдийн засаг хумигдахад хүрнэ. Эдгээр сөрөг үр дагаварын улмаас дэлхийн эдийн засагт хүндрэл учирвал хөрөнгийн урсгалд өндөр хэлбэлзэл үүсэх болно. Үүний улмаас дэлхийн эдийн засагт томоохон сөрөг үйл явдал гарахгүй боловч эрсдэлийн хүү нэмэгдэж, хөрөнгө оруулагчид аж үйлдвэржсэн томоохон орнуудын эдийн засгийн хэтийн төлөвийн талаарх хүлээлтээ өөрчилж, эрсдэл багатай орнуудад хөрөнгөө шилжүүлж болзошгүй юм.

Монголын эдийн засгийг улам бүр эмзэг болж байна

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал муудаж, Хятадын эдийн засгийн өсөлт эрс саарч байгаа нь экспортоор дамжин Монголын эдийн засгийн өсөлт, гадаад худалдааны тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж байна. Эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд 20 хувьтай байсан бол энэ оны эхний улиралд 16.5 хувь хүртэл буурч, гуравдугаар улиралд 5.6 хувьд хүрлээ. Энэ оны эхний есөн сарын байдлаар экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.1 хувиар буурч, импортын өсөлт 8.7 хувьд хүрч буурав. Экспорт, импорт энэ оны есдүгээр сарын байдлаар түрүү оны мөн үетэй харьцуулахад 39.3 болон 7.7 хувиар тус тус буурсан байна. Оны эхний хагаст урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 30 хувиар өсөж, 1.4 тэрбум ам.доллар, гадаадын

шууд хөрөнгө оруулалт хоёр хувиар өсөж 1.9 тэрбум ам.долларт хүрчээ. Дэлхийн эдийн засгийн уналтаас үл хамааран, Оюутолгой төслийн үйлдвэрлэл төлөвлөгөөний дагуу эхэлбэл ДНБ-ий хэмжээ энэ онд 11 хувиар, ирэх онд 12 хувиар тус тус өснө гэж тооцоолж байна. Энэ онд сангийн бодлого мөчлөг дагасан шинжтэй байна. Засгийн газрын зардал энэ оны эхний есөн сарын байдлаар нэрлэсэн дүнгээр 38 хувиар өндөр байлаа. Төсвийн орлогын өсөлт төсвийн зардлын өсөлтийн хурдыг гүйцэж чадахгүй байгаа бөгөөд зөвхөн 10.9 орчим хувиар өсчээ. Үүний улмаас төсвийн тэнцэл 532.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. өнгөрсөн оны мөн үед төсвийн тэнцэл 236.7 тэрбум төгрөгийн ашигтай гарч байсан юм. (2011 онд төсвийн алдагдал 391 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 3.6 хувьтай тэнцэж байв.) Энэ оны төсвийн тооцоог үзвэл зардал 32 хувиар, орлого 40 хувиар өссөөр байгаа. Энэ оны есдүгээр сарын дундуур УИХ төсөвт тодотгол хийж, орлогын тооцоог 10.6 хувиар хасаж, зардлын тооцоог 1.8 хувиар танаж, Засгийн газрын алдагдлыг ДНБ-ий 4.2 хувьд байхаар шинэчлэн тогтоосон. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар 2013 оны эхний сараас эхлэн төсвийн бүтцийн алдагдлыг хоёр хувийн хязгаарт барих ёстой болж байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар төсвийн зарцуулалтыг ихээхэн чангатгах шаардлагатай байна. Энэ онд төсвийн орлого байнга хомсдолтой байгаа нь улсын төсвийн орлогыг хэт өөдрөг байдлаар төсөөлж төсөв боловсруулах нь эрсдэлтэй болохыг харуулж байна.

Инфляцийн түвшин өнгөрөгч наймдугаар сард 14.8 хувьтай байсан. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд эрэлт, нийлүүлэлтийн дарамт хурдацтай өсөж буйг илтгэж байна. Энэ оны эхний хагаст төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэрийг хоёр үе шаттайгаар нэмэгдүүлсэн, эрэлтийн хэмжээ өндөр байгаа шалтгааны улмаас үнийн дарамт цаашид үргэлжлэх төлөвтэй байна.

Инфляцийн түвшин энэ онд 15 хувь, ирэх онд 12 хувь тус тус байна гэж төсөөлж байна. 2010 оны эхнээс мөнгөний бодлогыг Монголбанк чангатгасан бөгөөд бодлогын хүүг нийт 2.25 нэгж хувиар нэмэгдүүлж 13.25 хувьд хүргэж, банкны нөөцийг долоон нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэсэн. Мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлсний улмаас арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлт өнгөрсөн оны арваннэгдүгээр сард 75 хувиас энэ оны мөн үед ойролцоогоор 37 хувь болж буурав.

Ам.доллартай харьцах төгрөгийн ханш энэ оны тавдугаар сард 1316 төгрөгөөс энэ сард 1400 төгрөг болж таван хувиар суларсан байна. Урсгал тэнцлийн алдагдлын улмаас төгрөгийн ханшид учрах дарамт есдүгээр сарын дундаас эрс нэмэгдэж, Монголбанк гадаад валютын зах зээл дээр ам.доллар, юанийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар интервенц хийсэн.

Өнөөгийн дэлхийн эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдалд нийцүүлэн эдийн засгийн бодлогыг боловсруулах хэрэгтэй байна. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ цаашид их хэмжээгээр унавал Монголын эдийн засагт хүчтэй нөлөөлж, төрийн санхүү, урсгал дансанд ихээхэн дарамт учруулах болно. Өөр нэг томоохон эрсдэл бол Монгол улсын экспортын дийлэнх хувийг эзэлдэг БНХАУ-ын эдийн засгийн өсөлт ихээхэн саарч болзошгүй байгаа явдал юм. Төсвийн алдагдлыг бууруулахын тулд төсвийн зардлыг танаж, Засгийн газрын үндсэн зардлуудыг санхүүжүүлж, түүхий эдийн үнийн уналтаас сэргийлэх хамгаалалтыг бий болгох нь хамгийн түрүүнд хэрэгжүүлэх эдийн засгийн арга хэмжээ болж байна. Ялангуяа төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг чанд хэрэгжүүлж, Монголын нөөц баялаг нь зөвхөн эдийн засгийн өсөлтийг хангаад зогсохгүй, хүртээмжтэй өсөлтийг бий болгож, ядуурлыг бууруулахад чиглэсэн эдийн засгийн хөгжлийг хангах нь чухал байна. ■

ЗОЧИН

“ЭМЭГТЭЙЧҮҮД ТЭНГЭРИЙН ТАЛЫГ ДААЖ ЯВДАГ”

Б.ЦЭЦЭЭ

Киргизстан улсын анхны эмэгтэй ерөнхийлөгч Роза Отунбаева өнгөрсөн долдугаар сард зохион байгуулагдсан “Эмэгтэйчүүдийн манлайллын үндэсний чуулганд” оролцохоор Монгол улсад айлчилсан билээ. Засгийн газар дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд сэтгэл зүтгэлээ зориулсан тэрбээр Киргизстан улсын гадаад хэргийн сайд, Парламент дахь Социал Демократ намын бүлгийн дарга байжээ. Одоогоос хоёр жилийн өмнө буюу 2010 оны дөрөвдүгээр сард авлигад идэгдсэн Засгийн газар, өвдөг сөхрөм амьдралын өртөгийг Киргизстан улсын ард түмэн эсэргүүцэн, бослого гаргаж байсан. 2000 гаруй хүн амиа алдсан цуст мөргөлдөөнийг таслан зогсоож, улсаа эмх цэгцэнд оруулах үүднээс байгуулагдсан түр Засгийн газрыг Роза Отунбаева намынхаа бүрэн дэмжлэгтэйгээр тэргүүлж, улмаар ерөнхийлөгчийн албыг 2011 оны эцэс хүртэл хашиж байсан билээ. Улсынхаа хувь заяаг тэгшитгэсэн эмэгтэй ерөнхийлөгч гэдгээрээ нэрд гарсан Роза Отунбаеватай манай сэтгүүлч ярилцсаныг хүргэе.

-Таныг өмнө нь Монгол улсад ирж байсан гэж сонссон. Тэгвэл таны энэ удаагийн айлчлал өмнөхөөсөө ямар ялгаатай байх вэ?

Монголд би хоёр дахь удаагаа ирж байна. Өмнө нь Социализмын үед, 1990-ээд онд ирж байлаа. Тэр үед ЗСБНХУ-ын ЮНЕСКО-гийн Үндэсний хорооны даргаар ажиллаж байсан. Тухайн үед би Гадаад хэргийн яаманд ажиллаж байлаа. Өөрчлөн байгуулалт уриан дор явж байсан тэр үеэс хойш Монголд хөгжил дэвшил их гарчээ. Монгол улсын нам болон залуу иргэдийн тоо их юм. Хүмүүс комминуст намын үзэл суртлын нөлөөллөөс ангид сэтгэж эхэлнэ гэдэг бол яах аргагүй сэргэн мандалт.

-Өнгөрсөн хугацаан дахь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг дүгнэн хэлэхгүй юү?

-22 жилийн дараа ирэхэд танай улсад олон зүйл өөрчлөгдөж, сайхан болсон байна. Харамсалтай нь манай хоёр улсын хамтын замнал идэвхгүй явж иржээ. Олон улсын хурал цуглаан дээр монгол хүмүүстэй уулзаж, танилцах боломж их. Харин бүх зүйл дээр бид өөр өөр хэсэгт байх нь олонтой. Жишээ нь, танай улс НҮБ-д одоо Азийн бүлэгт харьяалагддаг болсон. Мөн Европын банк, Дэлхийн банк болон Азийн банкны ангилалд ч тэр өөр хэсэгт багтдаг. Тиймээс өнгөрсөн хугацаанд бидэнд бие биетэйгээ дотно нөхөрлөх боломж

дардан байгаагүй. Өөрөөр хэлбэл, бид бие биенээсээ хөндийрч, харилцаа холбоо тасарсан гэж хэлж болно. Хамгийн наад зах нь гэхэд би сая Истанбулаас Бишкек хүрч, тэндээсээ Улаанбаатар руу шууд нисч ирсэн. Энэ нь цаашдаа “Туркиш Эйрлайн” компанийн тогтмол нислэгүүдийн нэг болж байгаа юм билээ. Би үүнийг манай хоёр улсын харилцаанд гүүр тавигдаж эхэллээ гэж дүгнэж байгаа.

-Манайд ардчилал хөгжөөд 20 гаруй жил болж байна. Тэгвэл ардчилал томоохон ямар өөрчлөлтүүдийг Монгол болон Киргизстан улсад авчирсан гэж Та бодож байна вэ ?

-Манай улс ардчилсан засаглалтай дөнгөж танилцаж байгаа орон. Хэмжээгүй эрхт засаглалтай байсан оронд мэдээж танил бус байх нь тодорхой ч, ардчилал гэж юу болохыг бид сайн мэднэ. Намууд сонгуульд тэгш эрхтэйгээр оролцон, суудал авч эвсэн засагладаг. Аливаа зүйлийн хөгжлийн эхлэл бол улс төрийн энэ байр суурь гэдгийг бид мэднэ. Гэвч хөлөө олтлоо чамгүй олон жилийг үзэх байх.

Ардчилсан Парламент манай улсын нийгэмд засаглалын ил тод нээлттэй байдал, хамтын зөвшилцөлийг авчирч байна.

Нэг засаглалаас нөгөөд шилжих шилжилтийн үед танай улсын эдийн засаг маш хүндэрч, ард түмний амьдрал нэлээд туйлдсан тухай би сонссон. ▶▶



Гэсэн ч 2012 онд буюу өнөөдрөөр энэ улсыг харахад эдийн засаг, улс төрийн хөгжлийн хүрээнд маш өндөр амжилт гаргаж яваа гэж ойлгож байна. Нэн тэргүүнд, ардчилсан засаглал үр дүнтэй хэрэгжиж, амжилттай урагшилж байгаа нь илт байна. Өнгөрсөн хугацаан дахь зургаан сонгууль тайван болж өнгөрлөө. Найман жил үргэлжилсэн нэг намын засаглал нөгөө намд шилжлээ зэрэг ардчилал жинхэнэ утгаараа хөгжиж буйг илтгэх зүйл танайд олон байна.

-Эдийн засгийн хүрээнд Монгол, Киргизстан улс хамтарч ажиллах

ямар боломжууд байгаа вэ?

-Маш их бололцоо байгаа гэж бодож байна. Би айлчлалынхаа хүрээнд хамгийн сүүлд Монгол улсын ХХААХҮЯ-ны үйл ажиллагаатай /одоогийн ҮХААЯ/ танилцсан. Мөн танай Ерөнхийлөгч болон сайд нар манайд айлчилсан. Ингэхдээ Монгол манай улсад ноос, ноолууран бүтээгдэхүүнээ борлуулах нь зүйтэй гэдэг дээр ихээхэн шийдвэртэй хандсан юм. Киргизстан улсын хувьд энэхүү бүтээгдэхүүний хөгжилд ахиц дэвшил гаргах хэрэгцээ үлэмж байна. Манай улс танайхтай адил малчин өрх

олон бий. Танай улс ойролцоогоор хэчнээн сая толгой малтай вэ? 10-12 мянган малчин, долоон сая гаруй хонь, ямаатай. Харин танайд үүнээс тав дахин их мал бий.

Социализмын үед бид ав адилхан байсныг санадаг. Харин өнөөдөр манай улс ноосны хомсдолд орчихсон. Ноосыг Хятад болон Туркууд худалдаж авдаг. Гэвч гар урлаачдын хувьд ноосны үйлдвэрлэл эрхлэхэд багагүй бэрхшээл тулгардаг. Ноос, ноолуурын худалдааг маш чухал алхам гэж бодож байгаа.

-Тэгвэл манай улсад танайхаас юу нийлүүлбэл боломжтой вэ?

-Манайх их хэмжээний жимс, хүнсний ногоог танай улсад экспортлох боломжтой. Би танай улс хүнсний ногооны хэрэгцээгээ дотоод боломжоороо бие даан хангах сонирхолтой байгааг ойлгож байгаа. Гэвч танай улсын ХХААХҮЯ-ны сайд манай орноос хатаасан жимс болон бусад хүнсний ногоог худалдан авах санал тавьсан. Манайх гүйлс, алим зэрэг олон жимсийг хатаан боловсруулдаг. Танайх Оюутолгойд хөрөнгө оруулалт татаж байгаа шиг бид жимсний чанамал болон шүүс гэх мэт үйлдвэрлэлдээ хөрөнгө оруулалт татах хүсэлтэй байгаа. Товчхондоо үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт нэн шаардлагатай байна.

-Эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаарх үндэсний чуулганы үйл явцад Та ямар үнэлгээ өгөх вэ? Өмнөх хурлуудаас юугаараа онцлог байсан бол?

-Дэлхий ертөнц санхүүгийн хямралтай нүүр тулаад байна. Өнгөрсөн арван жилийн эхэнд Европ, АНУ мөн барууны орнууд хэрхэн үсрэнгүй хөгжлөөр амьсгалж байгааг бид харж суусан. Өнөөдөр дэлхий ертөнц бүхэлдээ хямралаас гарах арга замыг эрэлхийлж байна. Харин эмэгтэйчүүд бол түүнтэй тэмцэх нууц зэвсэг юм. Миний хувьд энэ жил 2-3 эмэгтэйчүүдийн эрхийн асуудлаарх хуралд оролцсон. Түүнээс гадна эмэгтэйчүүдийн мэдлэгт суурилсан эдийн засгийн талаар ярилцдаг тусгай хэсэг бүхий Европын сэргээн босголт хөгжлийн банк /ЕСБХБ/-наас жил бүр зохион байгуулдаг уулзалтад оролцсон. Тус хурал их сургууль төгссөн ▶



Фотог Б.Бямба-Очир

► эмэгтэйчүүдийн тэр дундаа эмэгтэй инженерүүдийн мэдлэг чадамжыг үр бүтээлтэй ашиглаж чадаж буй эсэх асуудлаар хэлэлцдэг юм.

Энэ оны сүүлчээр би Арканзасын Литтл Рок хэмээх газар руу явна. Би мөн хуучин ерөнхийлөгч, ерөнхий сайд нарын нэгдсэн клубын гишүүн. Энэ бол нэг төрлийн эмэгтэйчүүдэд зориулсан уулзалт юм. Улс орон болгонд хөгжлийг бий болгохын тулд үйлдвэрлэлд өөрсдийн хүчин чармайлтаа зориулдаг маш олон эмэгтэй байдаг. Дэлхий даяар өнөөгийн эдийн засгийн хөгжлөөс ангид хэчнээн эмэгтэй гэртээ суугаа бол? Тэд бол дэлхийн тал. Хятадын зүйр үг байдаг шүү дээ. “Эмэгтэйчүүд тэнгэрийн талыг дааж явдаг гэж”.

-Тэгвэл Таны цаашдын улс төрийн бодлого чиглэл чухам ямар асуудлууд дээр илүү төвлөрөх бол.

-Эдийн засагдахь эмэгтэйчүүдийн оролцоо их багаас үл хамааран чухал асуудал юм. Би хоёр асуудлыг чухалчилдаг. Нэгдүгээрт, бидний нийгэмд шууд хамаардаг авлигатай тэмцэх асуудал юм. Одоогийн түвшинд авлигатай тэмцэхгүй

аваас бид өвдөг сөхөрнө. Одоогоос хорин жилийн өмнө миний, чиний улс өөрчлөлтийн догшин шуурганд өртсөн билээ. Өмчлөлийн хэлбэр өөрчлөгдсөн. Улсад харьяалагддаг байсан бүхэн нийгмийн хэсэг бүлэгт очсон. Нэг шөнийн дотор зарим хүн яагаад хахаж цацатлаа баяжиж нөгөө хэсэг нь ядуу хэвээр үлдэх болов? Бидний адилаар танай улсын нийт хүн амын 30 хувь нь нэн ядууд багтаж байна. Яагаад ийм болчихсон юм бэ? гэж асууя. Бид бүх зүйлийг хүн бүрт эн тэнцүү хуваадаг эрх тэгш нийгэмд амьдардаг байсан шүү дээ. Иймээс ч би хүн болгон авлигыг нугачин дарах маш чухал зэвсэг гэдэгт итгэдэг.

Улс төр өөрийн эрх мэдлийн хүрээнд авлигатай тэмцэхэд бүх аргыг хэрэглэх нь зүйтэй. Түүнчлэн бүх гэр бүл тэмцэх хэрэгтэй. Гэр бүл бүр төрийн төлөө ажиллаж байгаад нэг шөнийн дотор маш их эд хөрөнгөтэй болно гэдэг хэр боломжтой вэ гэдгийг өөрсдөөсөө асууж үзэх хэрэгтэй юм. Энэ нийгэмд хүн бүр төрийн албан хаагчийн цалин хэд вэ гэдгийг мэднэ. Парламентад байгаа хүмүүс эд баялгаа хамгаалах гэж ажилладаг. Үүнийг харин ард

түмэн ажаад сууж байдаг.

Бидний хувьд Засгийн газрын өмчит болон хувь нийлүүлсэн компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн гишүүнчлэлийг бий болгох нь чухал юм. Яагаад захирлуудын зөвлөлд эмэгтэйчүүд байдаггүй юм бэ? Яагаад тэд энэ бүгдээс хоцрох ёстой гэж? Бид энэ бүхний төлөө тэмцэх ёстой. ТУЗ-ийн уулзалт мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар дээр суурилсан нээлттэй ил тод байх ёстой. Одоог хүртэл төлөөлөн удирдах зөвлөлийн мэдэлд нь маш их мөнгө эргэлдэж байдаг харилцаа холбоо, төмөр зам гэх мэт салбар олон байна. Ард иргэдийнхээ төлөө тэд зохих ёсны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна уу, үгүй юү гэдгийг бид мэдэж байх ёстой.

-2010 онд Киргизстанд бослого гарч засгийн эрхийг гартаа авахад тань дэлхий нийт таныг эмэгтэй хүн гэдэг утгаар өөр өөрөөр хүлээж авсан. Та өөрийгөө Засгийн газар дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд хэр их зүйл хийсэн гэж боддог вэ?

-Бүх өөрчлөлт, шинэчлэлийн тэргүүн шугаманд эмэгтэйчүүд байсаар ирсэн. Манай улсын хувьд лав өмнө нь Засгийн газрын эмэгтэй үүрэг гүйцэтгэгчтэй байгаагүй. Харин одоо бидэнд байна. Олон эмэгтэй хотын дарга, сайд болоосой гэж хүсэж байгаа. Манай улсад эмэгтэй нэг дэд сайд, хоёр дэд парламентийн дарга мөн цөөн тооны хорооны дарга бий. Харин Парламентийн 23 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг.

-Манай улсын Парламентад суудаг эмэгтэй гишүүдийн тоо энэ удаагийн сонгуулиар гурваас ес болсон. Үүнийг Та хэрхэн үнэлэх вэ?

-Энэ тоо гурав дахин өссөнд би хувиасаа халуун баяр хүргэмээр байна. Гэсэн ч үүний хажуугаар дүрэм, журам, зохицуулалтын хувьд тийм ч дэвшилттэй харагдахгүй байна. Бид пропорциональ системээр сонгуулиа явуулдаг. Намын жагсаалтаар нэр дэвшигч дөрвөн хүн тутмын нэг нь эмэгтэй нэр дэвшигч байдаг. Жагсаалтад орсон л бол түүнийг өөрчлөх, солих эрх хэнд ч байхгүй. Танай улс ч ийм төрлийн зохицуулалттай байх нь зүйтэй болов уу гэж бодож байна. ■

ТӨСӨЛ

ТАВАНТОЛГОЙН НҮҮДЭЛ

Б.ТОГТОХ

...Тавантолгойн ордод анхаарал хандуулах ажлын хэсэг бүрдлээ. Уул уурхайн сайд Д.Ганхуягаар ахлуулсан ажлын хэсэг уг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрт ихээхэн анхаарах бодлогыг баримталж буй аж. Учир нь дэлхийн зах зээлд төдийгүй өмнөд хөршид нүүрсний үнэ шалдаа буусан тул “саваа бэлдэх”-ээр шийджээ...

2011. Энэ онд “Эрдэнэс Тавантолгой” компанийн Баруун цанхид олборлолт явуулах консорциумын тендерийн хэлэлцээр ид өрнөж байв. Тус ордод олборлолт явуулах сонгон шалгаруулалтын хоёрдугаар шатанд АНУ-ын “Peabody Energy”, Хятадын “Shenhua Energy” болон Японы “Mitsui & Co” компаниудын консорциум, “Оросын төмөр зам” болон Японы консорциум, БНСУ-ын “Корес” группээр ахлуулсан компаниудын нэгдэл, Австралийн “Xstrata coal”, Бразилийн “Vale”, Люксембургийн “Arcelor Mittal” тунаж үлдээд байлаа.

2012. Энэ онд Баруун цанхийн ордын тендерийн шалгаруулалтад дээрх компаниас аль нь ч шалгарсангүй. Уг нь тендерт Хятадын “Shenhua Energy” 40 хувь, Орос-Монголын хамтарсан консорциум 36 хувь, АНУ-ын “Пийбоди энержи” 24 хувийг эзэмшихээр болж байсан юм. Гэвч стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах тендерийн дүнг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хүчингүй болгов. “Эрдэнэс МГЛ” компанийн гүйцэтгэх захирал Я.Долгоржав “Баруун цанхийн уурхайг удахгүй нээнэ. Хөрөнгө оруулалт

хүлээхгүйгээрирэхдөрөвдүгээрсарын дундуур нээнэ. Нээлтийн ёслолын дараа хөрсөө хуулж эхэлнэ. Энэ бол сонирхогч талуудын анхаарлыг улам татах, бодлогын шийдвэрүүдээ түргэсгэх утгаар компанийн зүгээс хэрэгжүүлж байгаа бэлтгэл ажил” гэж мэдэгдсэн.

2012.10.01. Баруун цанхийн хөрсийг хуулж, Тавантолгойн орд бүхэлдээ билгэдэл төдий эдийн засгийн эргэлтэд орлоо. Өнгөрсөн хугацаанд явж ирсэн “Эрдэнэс Тавантолгой” компанийн тендерийн сонгон шалгаруулалт улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан тэг зогсолт хийв. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчдад шинэ Засгийн газрын бодлого, Тавантолгойн ордод баримтлах хэтийн төлөвлөгөөг ажсан хүлээлт бий болов. Түүнчлэн гадаад зах зээлд нүүрсний үнэ унасан тул хөрөнгө оруулагчдын сонирхол даалуу нурах адил болов.

2012.10.15. Монголын эдийн засгийн хөгжлийн өнгийг тодорхойлох “Эрдэнэс Таван толгой”-н гүйцэтгэх захирал Б.Энэбиш ажлаа өөрийн хүсэлтээр өгч, УИХ-ын гишүүн асан Я.Батсуурийг түүний оронд томилов.

Монгол улсын хөгжлийн хувь заяатай холбоотой эл ордын гүйцэтгэх захирлын томилгоо өнгөрсөн хугацаанд өрнөсөн онцлох үйл явдлын нэг байв. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд шинэчлэгдсэн гээд тус компанийн удирдлагын түвшин “хөдөлгөөн”-тэй байлаа.

2012.10.16. Тавантолгойн ордод анхаарал хандуулах ажлын хэсэг бүрдлээ. Уул уурхайн сайд Д.Ганхуягаар ахлуулсан ажлын хэсэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрт ихээхэн анхаарах бодлогыг баримталж буй аж. Учир нь дэлхийн зах зээлд төдийгүй өмнөд хөршид нүүрсний үнэ шалдаа буусан тул “саваа бэлдэх”-ээр шийджээ. Үүнтэй зэрэгцэн Баруун цанхийн ордын тендер дахин шинээр эхлэх, тодруулбал, шинэ Засгийн газрын бодлогын хүрээнд сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, өмнөх хэлэлцээрийг сэргээх гэсэн хэд хэдэн зарчим үйлчилж эхэллээ. Гэхдээ “Эрдэнэс Тавантолгой” компанийн зүгээс Тавантолгойн ордын Баруун цанхид олборлолт хийх хүсэлтийг “Пийбоди Энержи” компанид хүргүүлсэн байна. Хэрэв хүсэлт хэлэлцээрийн ширээнд шилжвэл Баруун цанхийн нүүрсийг “Пийбоди Энержи” компани олборлоно гэсэн үг.

Тавантолгойн орд ашиг “үйлдвэрлэхгүй”, өр төлнө

Монгол улсын иргэн бүрийн өмч болох “Эрдэнэс Тавантолгой” компани Зүүн цанхийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж байсан бол Баруун цанхийн ордыг “түлхүүрдлээ”. Гэхдээ ►



► Тавантолгойн төрийн эзэмшилд буй бүлэг орд эдийн засгийн эргэлтэд орохын тулд багагүй саадтай нүүр тулах бололтой. Дэд бүтэц, ажиллах хүчин, хөрөнгө оруулалт, борлуулалт, зах зээл гээд нарийн тооцоо судалгаа түүхий хэвээр. Хамгийн наанадаж л төмөр замаа тавих, хаагуур хэрхэн ямар маршрут гаргах гээд Засгийн газраас шалтгаалсан бодлогын шийдвэр ч тодорхойгүй байгааг Хөгжлийн банкныхан учирласан юм.

Дэлхийд коксжих нүүрсний нөөцөөр тэргүүлэх Тавантолгойн бүлэг орд нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Улаан нуурын хөндийд буй. Энэхүү стратегийн орд нь 7.4 тэрбум тонн нүүрсний нөөцтэй бөгөөд үүний 1.4 тэрбум нь коксжих нүүрс бол 4.6 тэрбум нь эрчим хүчнийх. Баруун цанхийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах жил дамнасан хэлэлцээр таг чиг болох зуур Тавантолгой төслийн “галт тэрэг” хөдлөх дохиог хөрөнгө оруулагчид бус монголчууд өөрсдөө өглөө. Монголын Засгийн газар төвхнөж, түүнтэй зэрэгцэн стратегийн Тавантолгойн орд хөл дээрээ дөнгөж тэнцэв. Өөрөөр хэлбэл, Зүүн, Баруун цанхийн орд хамтдаа эдийн засгийн эргэлтэд орсноор Монгол улсын хэтийн ашиг зузаарах учиртайг албаны хүмүүс онцлон тэмдэглэж байна. Ирэх хавар Баруун цанхийн ордоос нүүрс олборлож эхлэх бөгөөд “Чалько” компанитай хийсэн нүүрсний урьдчилан борлуулах гэрээний дагуу “өрөө” төлөх аж.

Гайхаж магадгүй, Баруун цанхийн орд эдийн засгийн эргэлтэд орсон бол ашгаа шууд өгөхгүй. Угтаа эдийн засгийн эргэлтэд орсон хэмээн тэмдэглэх боловч

мөн чанартаа уурхайн олборлолт бус хөрс хуулалтын ажил өрнөж байна. Тиймээс ирэх жилээс “Эрдэнэс Тавантолгой” компанийн Баруун цанхийн ид шид гарна гэсэн үг. Энэ жилдээ уурхайгаас улсын төсөвт орлого орно гэж харалтгүй. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ирэх хавар олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа арилжаалах төлөвлөгөө хэсэг хугацаагаар хойшилж ч мэдэхээр байгааг тус компанийн ТУЗ анхааралдаа авчээ. Үүнд, гадаад болон дотоод гэсэн хоёр хүчин зүйлийн нөлөө бий. Нэгдүгээрт, гадаад зах зээл, Хоёрдугаарт, Төрөөс баримтлах төмөр замын бодлого. Энэхүү зөрүүтэй болон бүрхэг байдлаас улбаалан “Эрдэнэс Тавантолгой” компанийн ирээдүйн “үйлдвэрлэх” ашиг хэрхэх нь шалтгаалах билээ. Хэдий Тавантолгойн орд дэлхийн хэмжээний үлэмж орд боловч боломжит зах зээл нь урд хөрш. Түүнчлэн олборлосон нүүрсээ төмөр зам болон автозамаар тээвэрлэх төрийн бодлого ч жигдрээгүй яваа. Ирэх оны тавдугаар сард “Эрдэнэс Тавантолгой” компанийн IPO хийхээр төлөвлөж буй боловч нөхцөл байдал хаврын тэнгэр шиг хуйсгануур байна. Дэлхийн эдийн засгийн хамгийн хүнд үе ирэх онд тохионо гэж олон улсын шинжээчид онцлох болов. 2016 он гэхэд Тавантолгойн ордоос жилдээ 20 сая тонн нүүрс олборлох түвшинд хүрэхийн төлөө ажиллах боловч “хязгааргүй амралт”-ыг Хятадын зах зээл олгож болзошгүй нь. Өөрөөр хэлбэл, Монгол улсын Засгийн газар Тавантолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах гэж чармайсан ч зах зээл тааламжгүй байвал нүүрс ухах нь илүүц зардал болох юм. ►►

► 2013

“Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг олон улсын зах зээлд гаргах бэлтгэл ажил хуваарийн дагуу явж байна. Дэлхийн эдийн засаг хямралтай байвал IPO гаргах нь оновчтой биш. Таван толгой компани хэзээ үр ашигтай ажиллана тэр цагт хувьцааныхаа ногдол ашгийг иргэд хүртэнэ” гэж тус компанийн шинэхэн гүйцэтгэх захирал Я.Батсуурь онцлов. Тэрбээр “Уурхайгаа хөл дээр нь босгохын төлөө ажиллана. Өмнөх алдааг засахын тулд гадаад, дотоодын санхүүгийн орчноос нэмэлт зээл авах талаар судалж, ярилцаж байгаа” гэв. Дэлхийн болон Хятадын эдийн засаг сэргэсэн тохиолдолд ирэх зунаас “Эрдэнэс Тавантолгой” төрийн өмчит компани нүүрсээ экспортлох бөгөөд хүчин чадлын хувьд Зүүн, Баруун цанхиас жилд тус бүр 20 сая тонн нүүрс олборлох дэлхийд тэргүүлэх хэмжээний уурхай болох зорилт тавьжээ. Баруун цанхи ордын тухайд олон улсын “Жорк” ангиллаар нөөцийг нь 1.2 тэрбум тонн гэж тогтоосон байна. Ил уурхайн хөрс хуулалтаа эхлүүлсэн тус ордоос ирэх онд 1-2, 2014 онд дөрөв, 2015 онд 12, 2017 онд 20 сая тонн нүүрс олборлож, 2016 онд нүүрс баяжуулах, угаах үйлдвэр ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. “Эрдэнэс Тавантолгой” компанийн зүгээс Нүүрс баяжуулах үйлдвэрийн зураг төслийг Австрали, Америкийн хамтарсан компани гүйцэтгэж байгаа аж. Баяжуулах үйлдвэр барих ажлыг ирэх хавраас эхлэх бөгөөд 2015 оны эхээр эхний модулийг ашиглалтад оруулахаар тооцжээ. Үйлвэр барихад нийтдээ 580 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай аж. Харин эрчим хүчний асуудлыг

шийдвэрлэхээр Засгийн газраас Тавантолгойн ордыг түшиглэн 300 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих зөвшөөрөл олгоод байна. Ирэх онд цахилгаан станц барих ажлыг эрчимжүүлэхээр төлөвлөжээ. Боловсруулах үйлдвэрийн тухайд Тавантолгой уурхайд жилд дунджаар 5.5 сая тонн коксжих нүүрс, 3.7 сая тонн эрчим хүчний нүүрс, нэг сая тонн завсрын бүтээгдэхүүн, нийтдээ 15 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадал бүхий угаах, боловсруулах үйлдвэр байгуулахаар ажилдаа орсон гэж тус компаниас мэдэгдсэн юм.

Төгсгөлд нь

Тавантолгой төслийн хүрээнд хамгийн чухалд тооцогдох Баруун цанхийн уурхай дээр хэн, хэрхэн үйл ажиллагаа явуулах вэ гэдэг оньсого мэт асуудал болов. Учир мэдэх эх сурвалжуудтай уулзаж сонссон сониноосоо хуваалцъя. “Эрдэнэс Тавантолгой” компанийн зүгээс санал болгох гурван хувилбарыг танилцуулсан юм. Нэгдүгээрт, 2011 онд Орос, Хятад, АНУ, Солонгос, Японы компаниуд оролцсон консорциум байгуулах хувилбарууд үргэлжлэх үү. Хоёрдугаарт, “Эрдэнэс Тавантолгой” компани Зүүн цанхийн уурхайг эхлүүлсэн загвараараа үйл ажиллагааг эхлүүлэх /Баруун цанхийн уурхайн хөрсийг хуулсан/. Гуравдугаарт, геополитикийн хувилбараар авч үзвэл, “дундын хувилбар”-аар явж болох юм. Гэхдээ энэ нь компаниас давсан Засгийн газрын түвшинд шийдэх асуудал аж. Ирэх өдрүүдэд дээрх хувилбаруудын нэг нь “тодрох” нь ойлгомжтой. ■

KHATAN TUUL
Pure Water

Packaging quantity of Pure water:	Маркетинг: 99071655
0.35 L /bottled/	Захиалга авах утас: 70173386
0.6 L /bottled/	Факс: 976-11-70174494
1 L /bottled/	
19 L /ballon/	

Produced and bottled by "Welmon Trade" Co., Ltd of Mongolia

КЛАСТЕР

ХЯМРАЛЫГ ХАМТДАА ДАВАХ УХААН

Х.ХУЛАН

Шинэ санаа гаргагч аливаа хүнийг тухайн санаагаа хэрэгжүүлэн амжилт олох хүртэл жигтэйд тооцдог.

Америкийн зохиолч Марк Твейн

“Радиус 66” зарчим нэг хэсэг шуугиан дэгдээж байлаа. Австрийн “Фло” хоолны газрын эзэн Йозеф Фло нь өөрийн ресторанаас хамгийн холдоо 66 км зайтай орших газраас л хүнсээ авна гэж мэдэгдсэн. Тэрбээр амлалтаа биелүүлж, хоолныхоо газарт зөвхөн ойролцоох орон нутгаас гаралтай бүтээгдэхүүнийг хэрэглэх болсон юм. Түүгээр ч зогсохгүй, ханган нийлүүлэгчдийнхээ зургаар хоолны зэсийг чимдэг байсан нь тухайн үедээ олны гайхшрулыг төрүүлж байв. Йозеф Фло энэхүү санаачилгаа одоогоос 15 жилийн өмнө өрнүүлсэн. Тэрбээр “Би зоогийн газартаа Бельги улсаас ирсэн био-загасаар хоол хийж үйлчлэхийг хүсээгүй юм” гэж учирлаж байжээ. Энэхүү жишээ нь дотоодын зах зээлээ тэр тусмаа орон нутгийн нөөц бололцоогоо хэрхэн инновацитай ашиглаж бүс нутгийн эдийн засгийг дэмжиж буйг харуулж байна.

Кластер гэж юу вэ?

Эдийн засаг нь шинжлэх ухааны нэгэн салбарын хувьд онол, томъёогоор баялаг. Харин эдгээрээс бизнест ид шидээ гаргаж буй нэгэн онолыг энэ бичлэгээрээ танилцуулахыг хичээлээ. АНУ-ын

Харвардын их сургуулийн профессор Майкл Портер өрсөлдөх чадварыг кластерын аргаар сайжруулах онол боловсруулсанаа 1990 онд нийтэд дэлгэсэн юм. Портер “Улс орнуудын өрсөлдөөний давуу байдал” (The Competitive Advantage of Nations) номондоо кластерын онолын суурийг тавьсан аж.

Түүний 1998 онд хэвлүүлсэн “Өрсөлдөөнд” (On Competition) бүтээлд кластерыг дараах байдлаар тодорхойлжээ. “Кластер нь газарзүйн байршилдаа тулгуурлан хэлхээ холбоо тогтоон бөөгнөрч нэгдсэн компаниуд, тэдгээрт бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгч тухайн салбарын аж ахуйн нэгжүүд, түүнчлэн тэдгээр компанийн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд тодорхой салбарт өрсөлдөхийн зэрэгцээ мөн хамтран ажилладаг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, агентлагууд, худалдааны нэгдлүүдээс бүрддэг” (Эх сурвалж: Л.Цэдэндамба “Кластерын хандлагад тулгуурлан Монгол улсын хөгжлийг хурдасгах зарим арга зам юу вэ”). Энгийн үгээр хэлбэл, кластер нь тухайн бүс нутагт нэг төрлийн бизнесийн үйлчилгээ үзүүлэгч компаниудыг нэгтгэсэн сүлжээ юм. Сүлжээ болж нэгдсэн компаниуд их, дээд сургууль,

судалгаа шинжилгээний болон төрийн холбогдох байгууллагуудтай нэмүү өртөг бий болгох замаар хамтарч ажиллахыг хэлнэ. Онцлоход, кластер нь нь гурвалсан ороомог хэлбэрийн бүтэцтэй.

Кластерын онолыг анх аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд зориулж гаргаж байсан түүхтэй. Тэгвэл одоо нэгдсэн зорилготой сүлжээний удирдлага доорх компаниудын үр бүтээмж болон инновацийг кластерын оролцогч талуудын оролцоотой хамтын ажиллагаагаар хэрэгжүүлдэг туршлага болж тогтжээ. Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн (ҮХХ) эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор Л.Цэдэндамба кластерыг хөгжүүлснээр дараах давуу тал бий болдог гэж судалгааны ажилдаа бичсэн байна. Үүнд: “Кластерын бүрэлдэхүүнд орсон компаниудын үйлдвэрлэл, үйлчилгээний зардал буурна. Өрсөлдөх чадвараа дээшлүүлэх орчин бүрдэнэ. Гадаад, дотоод зах зээлд гарах боломж сайжирна. Засгийн газар, бизнес, шинжлэх ухаан гэсэн гурван талын хамтын ажиллагаа илүү өндөр түвшинд гарна. Кластерын зохион байгуулалтад орсон компаниудын хөрөнгө оруулалтын болон технологийн боломж нэмэгдэнэ” гэжээ.

Кластерын мөн чанар

Кластерыг дэлхийн олон орон ►



яагаад хэрэгжүүлдэг вэ? Европын Холбооны орнууд төдийгүй манай хойд болон урд хөрш кластерын аргыг хөгжлийн бодлоготоо тууштай хэрэглэх боллоо. Кластерын санаачлагын ачаар “акул” аж ахуйн нэгжүүд нь жижиг компаниудаа “асарч”, тэдэнд мөр зэрэгцэн алхах боломжийг гаргаж өгч байна. Эдийн засгийн хямрал, бэрхшээл тулгарахад компаниуд ганц нэгээрээ бус, сүлжээгээрээ хэлэлцэн шийдэх нь илүү үр дүнтэйг кластерын амжилтын түүх бүр өгүүлнэ. Яагаад? Хамтарч ажилласан кластерүүд дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүн үйлчилгээгээ гаргах нь илүү хялбар, нээлттэй болдог. Мөн их, дээд сургууль, судалгааны байгууллагуудтай хамтарснаар зах зээл дээр инновацитай бүтээгдэхүүн гаргана. Өөрөөр хэлбэл, инновацийн арвин ургац хураах боломж бүрддэг ажээ. Үүний тод жишээ бол Америкийн “Цахиурт хөндий” (Silicon Valley) кластер юм. Анхаарах зүйл бол өнөөдөр эхлүүлээд маргааш нь санхүүжилт, менежментийн асуудлаас болж кластераа орхих бус, хамтын хүчээр он удаан жил хөгжүүлэн цэцэглүүлэхэд ухаанаа зарна. Иймд кластерыг хямралыг хамтдаа даван туулах арга ухаан гэж тодорхойлж болно.

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгдүгээр бүлэгт “Ажилтай, орлоготой

монгол хүн” хүн гэсэн заалт орсон билээ. Үүнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргаж, бизнест ээлтэй орчныг бүрдүүлэх нь тэргүүлэх зорилтын нэг байна гэсний дагуу манай Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ) кластерын бодлого боловсруулах ажилд ханцуй шамлан орж буй. Эхний ээлжинд Засгийн газрын санаачилгаар мах, ноос, ноолуур, арьс шир, чацаргана, уул уурхайн салбарын компаниудад ханган нийлүүлэгчдийн кластерыг байгуулах зорилт дэвшүүлсэн байгаа гэж тус яамны Кластерийн бодлого, стратеги хариуцсан мэргэжилтэн Д.Анударь хэллээ.

Кластер нь аливаа улс гүрний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хөшүүрэг болохоос гадна бүс нутгийн эдийн засгийг бэхжүүлэх чухал арга хэрэгслийн үүргийг гүйцэтгэж байна. Үүнийг дэлхийн олон оронд хэрэгжиж буй инновацитай кластерын санаачилгууд нь илтгэнэ.

ХБНГУ-ын кластерын туршлагаас

Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын хүсэлтээр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрөөс ХБНГУ болон Австрийн кластерын хөгжил, бодлого, түүнчлэн кластерт хэрхэн үнэлгээ

хийх аргачлалын сургалт аяллыг өнгөрсөн сарын 23-наас энэ сарын 4-ний хооронд зохион байгууллаа. Эдийн засгийн хөгжлийн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Боловсрол шинжлэх ухааны яамны мэргэжилтнүүд, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судлаач, МУИС, Удирдлагын академийн багш нар оролцож Герман, Австрийн кластерын мэргэжилтэн, менежерүүдтэй санал бодлоо солилцлоо.

ХБНГУ-д кластерын санаачилгыг бүсийн эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хэрэгжүүлж байна. Кластерын санхүүжилтийг үндэсний болон мужийн түвшинд авч үздэг байна. Түүнчлэн энэ чиглэлийн санаачилгыг үүсгэн байгуулах хоёр гол хэлбэр байдаг аж. Эхний буюу дээрээс доош (top-down) чиглэсэн кластерыг төрийн санаачилгаар үүсгэн байгуулдаг. Нэг үгээр хэлэхэд, төрийн санхүүжилтээс шууд хамааралтай, улс төрийн нөлөөн дор байдаг гэж хэлж болно. Төсвөөс тодорхой хугацаанд санхүүжүүлж байгаад яваандаа кластерыг бие даасан санхүүжилттэй болгох зорилготой. Хоёр дахь хэлбэр нь харин доороос дээшээ (bottom-up) хандсан санаачилга юм. Энэ нь хувийн хэвшил болон судалгааны салбараас гаргасан санаачилгад тулгуурласан кластерын хэлбэр бөгөөд улс төрийн нөлөөлөл бага. Сонирхуулахад, Германы хамгийн их инновацитай ▶

Баден-Вюрттемберг мужийн шинжлэх ухаан, технологийн дэд бүтэц

Их, дээд сургууль

- Их сургууль
- Дээд сургууль (мэргэжлийн)
- ★ Мэргэжлийн академи
- ◆ Хувийн их сургууль
- ★ Элит их сургууль



Баден-Вюрттемберг муж нь их, дээд сургууль, судалгаа шинжилгээний байгууллагын хамгийн орчин үеийн бүтэцтэй.

Есөн их сургуультай. Үүний дөрөв нь “Элит Их Сургууль” нэртэй бөгөөд эдгээр нь Хайдельберг, Фрайбург, Карлсруэ, Констанц хотод тус бүр байрладаг.

41 дээд сургууль, найман мэргэжлийн академи, 21 хувийн их сургуультай. Технологи нэвтрүүлэх Штайнбайсын төвүүд нь хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудын хооронд гүүр болдог.

▶ кластерын 25 хувийг энэхүү доороос дээшээ хэлбэрийн санаачилга эзэлдэг. Мөн дээрээс доошоо чиглэсэн кластерын санаачилгыг бодвол олон улсын зах зээлд илүү нээлттэй байж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэвтрүүлж эхэлсэн байдаг гэнэ. Энэхүү хоёр аргачлалыг хоршуулсан холимог хэлбэр гэж мөн байдаг ч дээрх хэлбэрийн аль нэгийг нь түлхүү агуулдаг.

ХБНГУ-д кластерын санаачилгыг анх Хессен мужид 1993 онд бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих хөтөлбөр боловсруулсанаар эхлүүлжээ. Харин 2007 оноос мужийн хэмжээнд кластерыг хэрэгжүүлдэг болсон аж. Жишээ нь, тус мужийн 2012 оны санхүүжилтэд Засгийн газраас долоон сая еврогийн төсөв баталсан. Үүнээс гадна Европын Холбооноос Хессен мужийн бүх кластерт 2007-2013 оны хооронд нийт 10.5 сая еврогийн санхүүжилт төлөвлөсөн байна. Хессен мужийн Эдийн засаг, тээвэр, мужийн хөгжлийн яамны мэргэжилтэн Хайке Бассе илтгэлдээ эдийн засгийн хөгжил сул орон нутагт кластерын үйл ажиллагааг чиглүүлдэг гэж дурдав. Өнөөгийн байдлаар 1100 гаруй компани нийт 35 кластер болж нэгдэн Хессен мужид үйл ажиллагаагаа явуулж байна. Тэд мэдээллийн технологи, оптик, машин үйлдвэрлэл, бичил системийн техник, эрүүл мэнд,

байгаль орчны технологийн салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

Кластерын сургалтын аяллын үеэр Баден-Вюрттемберг мужийн Санхүү, эдийн засгийн яамны зөвлөх доктор Михаэль Хагенмейер мужийн кластерын бодлогыг танилцуулсан билээ. Улсынхаа төдийгүй дэлхийн эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэсэн тус мужийн төв нь Штуттгарт хот. Германы муж бүр өөрийн гэсэн онцлогтой ч Баден-Вюрттембергийн хувьд тусгайлан авч үзэхгүй байхын аргагүй билээ. Учир нь тус муж Европын Холбоо дотор инновациараа топ арван бүс нутагт ордог. Түүнчлэн ДНБ-ий хэмжээ 380 тэрбум евро бөгөөд Бельги, Норвеги, Австри улсынхаас хол давсан тоо юм. Аж үйлдвэрийн салбарт зөвхөн нэг техник, технологи хангалтгүй болсон үед хоёр салбарыг хоршуулах явдал элбэг болсон. Үүний нэг жишээ бол машины эд ангийн салбарыг мэдээлэл технологийн уялдуулах.

Доктор Хагенмейер Герман улс байгалийн баялгийн нөөцөөр хомс орны хувьд боловсрол, шинжлэх ухааны салбарт хөрөнгө түлхүү оруулдаг хэмээв. Иймд мужийн Санхүү, эдийн засгийн яамнаас аж үйлдвэр, эрдэм шинжилгээнд чиглэсэн бодлогод анхаардаг тухай яриу. Баден-Вюрттембергийн бас нэг онцлог нь Германы уламжлалт их,

дээд сургууль, томоохон судалгаа шинжилгээний байгууллагууд болох Фраунхофын болон Макс-Планкийн институт байрладаг явдал юм. Эдгээр судалгааны байгууллагууд мужийн компаниудтай нягт хамтран ажилладаг. Баден-Вюрттембергт нийт 103 орон нутгийн кластер байдаг. Бүгд инновацийг урт хугацаанд хөгжүүлж, хэрэгжүүлэх нийтлэг зорилготой аж. Тус муж нь автомашин үйлдвэрлэл, байгаль орчны технологи, ойн аж ахуй, биотехнологи, логистик, мехатроник, эрчим хүчний салбараар алдартай. ▶



“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

Монголд кластерыг хөгжүүлэх нь эдийн засгийн хөгжилд ямар ач холбогдолтой вэ? Кластерын менежментийн сургалтын аяллаас Та юу суралцсан бэ?

Л.ЦЭДЭНДАМБА /Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор/:

-Кластерыг хөгжүүлснээр жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимтэй хөгжиж ажлын байр олноор бий болж, ядуурлыг бууруулах таатай орчин бүрддэг гэж НҮБ үзэж байна. Монголд эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн салбарын бүтцийг шинэчлэх, инновацийн бодлогыг хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, улмаар улсын болон бүс нутгийн түвшинд үйлдвэрлэл, үйлчилгээг оновчтой хөгжүүлж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах хэрэгцээ шаардлага байна. Амин чухал энэ зорилтыг хэрэгжүүлэхэд үндэсний болон бүс нутгуудын түвшинд үйлдвэрлэл, үйлчилгээний кластеруудыг хөгжүүлэх нь онцгой ач холбогдолтой гэж үзэж буй. Бидний танилцсан Герман улсын туршлага ч ийм л байна. Өнөөгийн

өндөр хөгжсөн болон хурдацтай хөгжиж байгаа орнууд үйлдвэрлэл, үйлчилгээний кластерыг хөгжүүлэн өрсөлдөх чадвараа дээшлүүлж, дэлхийн зах зээлд байр сууриа тэлсээр.

Хэрэв бид кластерыг салбар бүрт оновчтой хөгжүүлж чадвал түүхий эдийн бус, нэмүү өртөг шингэсэн өндөр технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, экспорт өсөж, эдийн засгийн салбарын бүтэц сайжирна. Мөн жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжиж, ажлын байрны хангамж нэмэгдэнэ. Мэдлэгт суурилсан эдийн засаг бий болж, бүс нутгууд хөгжих болно. Саяхан би “Монгол улсад үйлдвэрлэл, үйлчилгээний кластеруудыг хөгжүүлэх үзэл баримтлал”-ын төсөл боловсруулсан.

Б.БАТЦЭЦЭГ /Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн/:

-Кластер нь хамтын ажиллагаан дээр түшиглэдэг. Тухайлбал, манай хөнгөн үйлдвэрийн салбарт кластерыг хэрэгжүүлэх бүрэн боломжтойг Германд болсон сургалтаас ойлгосон. Ялангуяа ноолуурын салбарын зах зээл хязгаарлагдмал учраас гадаад зах зээлд хандсан бодлого явуулах шаардлагатай. Кластерыг зөвхөн ганц, хоёр том үйлдвэр өөрийнхөө бүтээгдэхүүнийг экспортлох биш, жижиг компаниудын тустуудаа явуулж байгаа үйл ажиллагааг нэгтгэвэл илүү үр дүнд хүрнэ. Мөн эрдэм шинжилгээний байгууллагууд судалгаа шинжилгээний ажлын санхүүжилтээ яаж олох вэ гэдэг болохоос биш, өөрсдийнхөө боловсруулсан технологи, гаргасан инновацийн төслүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх тал дээр үйлдвэрлэгчидтэй хамтарч ажиллаж чаддаггүй. Үүнээс

болоод тэдний хийж байгаа ажлыг ойлгодоггүй.

Инновацийн судалгаа хийх, төслийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд хамгийн том шалтгаан нь санхүүгийн бэрхшээл. Ийм учраас кластерын бүтцэд орж ажилласнаар эрдэм шинжилгээний байгууллагуудын санхүүгийн асуудал шийдэгдэх боломжтой болно. Тэдний хийж байгаа ажлыг үйлдвэрлэгчид авч хэрэгжүүлнэ. Инновацитай бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах бүрэн боломжтой. Мөн энэ тал дээр мэргэжлийн холбоод их үүрэгтэй. Кластер байгуулахын тулд нэгдсэн зорилго, бодлого, хэтийн төлөвөө гаргаад, тодорхой зорилтууд тавьж, хамтарч ажиллах ёстой. Их, дээд сургуулиуд, хувийн хэвшил, төр гэсэн гурван тал нягт хамтарч, дутуугаа нөхөж жигд ажилласнаар амжилтад хүрнэ.

Д.АНУДАРЬ /Эдийн засгийн хөгжлийн яамны Инноваци, төр хувийн хэвшлийн түншлэлийн газрын Кластерийн бодлого, стратеги хариуцсан мэргэжилтэн/:

-ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн боловсруулсан программын дагуу ХБНГУ-ын Хессен мужийн Эдийн засаг, тээвэр, мужийн хөгжлийн яам, Баден-Вюртемберг мужийн Санхүү, эдийн засгийн яамны кластерийн бодлого боловсруулагчидтай уулзсан нь Европын, Холбооны болон мужийн засаг захиргаанаас баримталж буй кластерын бодлого, чиг хандлага, бодлого боловсруулах үйл явц, эрдэм шинжилгээ ба үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хэрхэн уялдуудах, кластерыг хэрхэн дэмжиж буй талаарх мэдээллийг авлаа. Энэ нь кластерын бодлого боловсруулахаар ажиллаж буй бидний хувьд маш чухал туршлага болсон. Уулзалтын үеэр яамны мэргэжилтэн хатагтай Хайке Бассе 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралыг ХБНГУ хохирол багатай даван туулахад кластер чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг онцолсон. Иймэрхүү хамтын

ажиллагааны хандлага манай улсад маш дутмаг байгаа бөгөөд кластерыг хөгжүүлсэнээр аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцаа, итгэлцэл бэхжинэ гэдэгт итгэж байна.

Монгол улсын хөгжил, эдийн засгийн тогтвортой байдал, төрөлжилтөд кластер чухал ач холбогдолтой юм. Кластерыг хөгжүүлсэнээр төр хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргаж, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэржилтийн холбоог бэхжүүлэх боломжтой. Кластерын бодлогыг боловсруулахаас өмнө, эхний ээлжинд яамд, төр засгийн байгууллагуудад энэ талаарх мэдлэгийг олгож, нэгдмэл ойлголттой болох шаардлагатай. Оролцогч талууд кластерын талаар ойлголттой болсоны дараа бодлого, стратегийг боловсруулан нэгдмэл зорилготой ажиллах боломжтой болно. ■

Үргэлжлэл бий